

Удо Б. Баркман
МУИС-ийн зочин профессор

Монгол дахь улс төрийн намууд ба ардчиллын үйл явц

Өгүүлийн товч утга: Монгол оронд улс төрийн бүлэглэл, нам бий болсон түүх, тухайн цаг үед явуулж ирсэн улс төрийн бодлого болон 1990 оны ардчилсан хувьсгалаар Монголд бий болсон улс төрийн нөхцөл байдал, улс төрийн намын системийн төлөвшилт. Шинэ Үндсэн хууль батлах үеийн улс төр, нийгмийн байдал, шинээр бий болсон намын системийн хөгжилт, цаашдын хандлага.

Түлхүүр үг. Нам, бүлэглэл, зүүнтэн ба баруунтан, бовьшевикуудын улс төрийн хавчилт, Монгол орон ба перестройка, намын систем, ардчилсан сонгууль, ардчилсан улс төрийн тогтолцоо, ардчилсан парламент, Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн сонгууль

Түүхэн урьдчилсан нөхцөл байдлын талаар:

Гадаад Монгол улс дахь монголчууд нь 20-р зууны хоёрдугаар хагас хүртэл эрчимжээгүй мал аж ахуй дээр суурилсан нүүдэлчний нийгэмд амьдарч ирсэн билээ. Энэхүү нийгэм нь 1911 оныг дуустал нийгмийн хөгжлийн хувьд нэг их гүн гүнзгий хувьсал өөрчлөлтийг үзэлгүй явсаар ирсэн харьцангуй энгийн бүтэцтэй нийгэм байлаа. Хүн амын дийлэнх хэсэг болсон малчид нь Манж Чин улсын эзэн хаан болон өөрийн орны засаг ноёд, угсаат сурвалжит тайж нар, шарын шашны том хуваргууд болон олон тооны лам нартай сөргөлдөх байранд зогсож байлаа. Хуримтлагдсан хөрөнгө нь ердөө л мал сүргээс бүтэж байв. Ийм учраас эдний баялаг, хөрөнгө гэдэг нь тун харьцангуй ойлголт мөн бөгөөд бэлчээрийн чанар чансаа, газар зүйн орчин нөхцлийн тогтвортой байдал болон мал сүргийн тоо толгойн эрүүл эсэх байдлаас энэхүү баялгийн хувь заяа шууд хамааралтай байх нь мэдээжийн хэрэг билээ. Ийм нөхцөл байдлын улмаас хөрөнгийн хуримтлал явагдах бараг боломжгүй ба ялангуяа нэмүү бүтээгдэхүүн нь жинхэнэ утгаараа байсан ч үгүй. Нүүдэлчний амьдралын оршин тогтнох нөхцөл нь газар зүйн хувьд байршлаа байнга сольж байх ёстой байдаг. Гэтэл 1691 оноос Чин гүрний үеэс эхлэн Гадаад Монгол оронд хошууны засаг захиргааны шинэ дэглэм тогтоож өгсний улмаас нүүдэлчид тусгайлан зааж өгсөн нутаг дэвсгэрийн хүрээнд л бэлчээрээ хязгаарлах ёстой боллоо.

Монголчуудыг нэгтгэх судас нь шарын шашин байв. Бас нэг зүйл нь нэгдмэл зөв бичих дүрэмтэй, үсгийн системийн хувьд өөр өөрийн нутгийн аялгуугаар уншиж болдог монгол бичиг, түүгээр туурвисан олон зуун жилийн судар ном байв. Шарын шашны сүм хийдийн өргөн сүлжээ Монгол орны нутаг дэвсгэрээр тархан байрлах болов. Хорвоод эргэн төрсөн амьд бурхан гJe-btsun dam-ра гэгээн нь хэдийгээр Гадаад Монголын шашны тэргүүн хэмээн тооцогдож байсан ч тэр үед шашны зүгээс засгийн эрхийг барих зэрэг зиндааны тодорхой тогтсон бүтэц байсангүй. Гадаад Монгол оронд нийгмийн аливаа бүлэглэлүүдийн ашиг сонирхолыг илэрхийлсэн улс төрийн байгууллагууд хэмээх ойлголт огт байгаагүй хэдий ч Манж Чин төрийн засаг захиргаа нь эзэрхийлэн захирах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд монголчууд өөрснөө улс төрийн аливаа зохицуулалт хийх гэсэн бүхий л оролдлогуудыг үр хөврөл төдий байхад нь боомилон дарж байжээ. Тайж язгууртнаасаа эхлээд нийтээрээ бичиг үсэг тун бага мэддэг байсан, түүнээс улбаалаад улс төрийн мэдлэг боловсрол бүрэлдэн тогтох боломжгүй байсан, мөн сийрэг хүн амтай байх зэрэг хүчин зүйлүүд нь зохион байгуулалттай улс төрийн хүсэл сонирхол бий болох ямар ч бололцоог олгоогүй байна.

1920 онд Монгол Ардын Нам (өнөөгийн МАХН) нь Гадаад Монгол дахь анхны улс төрийн нам болон байгуулагдсан байна. Энэ намыг үндэслэн байгуулахад багагүй үүрэг гүйцэтгэсэн оросын большевикууд МАН-ыг нам ямар байх ёстой хэмээх өөрсдийн европ зүгийн ойлголтоор цааш авч явахаар

оролдож эхлэв. Ямар ч атугай МАН нь большевикуудад нийцүүлсэн зохион байгуулалтын нөхцөл бололцоог нь бүрдүүлж өгөх ёстой болсон билээ. Ингэснээрээ тэд Гадаад Монголд богино хугацаанд улс төрийн элитийг бий болгож, тэднийг большевикуудын үзэл санаагаар хүмүүжүүлж, удаан хугацааны турш үзэл сурталдаа оруулан залуурдах үйл ажиллагаа эхлүүлээ. Большевикууд монголын улс төрийн элитийн хүчээр монголын нийгмийг өөрсдийн хүссэнээр өөрчлөн байгуулах зорилготой байв. Зөвлөлийн орныхон анхнаасаа эхлэн Гадаад Монгол оронд нэг намын ноёрхлыг тогтоож чадсан учраас зөвхөн МАН (хожим нь МАХН)-ын элит аажим аажмаар төр засгийн гүйцэтгэх эрхийг гартаа авсан билээ. Үйлдвэрчний Эвлэл, МХЗЭ болон эмэгтэйчүүдийн зэрэг бусад улс төрийн байгууллагууд нь ард иргэдийг улс төрийн үзэл сурталд оруулах үүрэгтэй байсан учраас улс төрийн хүсэл санааг илэрхийлэх байгууллага болон хөгжиж чадаагүй байна. Монголын улс төрийн элит 1928 оныг хүртэл үндэсний ардчилсан хөгжлийн чиг баримжааг өөрийн орны үзэл баримтлал болгохоор зүтгэж байхад зөвлөлтөөс ирсэн зөвлөхүүд энэхүү үзэл баримтлалыг нь алхам алхмаар нь марксист чиг баримжаагаар орлуулсаар байлаа. Үндэсний элит нь зөвхөн Хятадаас тусгаар тогтносон үндэсний улсаа үндэслэн байгуулж хамгаалан авч үлдэх, түүнийг хөгжүүлэх асуудал руу хандсан хязгаарлагдмал хүрээний дотор л үндэсний ардчилсан хөгжлийн чиг баримжаагаа боловсруулсан байсныг анхааралдаа авах шаардлагатай юм.

Зөвлөлтийн орноос хиймлээр зохион, хүчээр тулгасан "барууны хэлбэрэл ба зүүний нугалаа завхрал"-ын үр дүнд 1928 оноос эхлэн элитийг халж солих ажил өрнөв. Үндэсний ардчилсан үзэл баримтлалын төлөө тэмцэгч элитийн оронд улс төрийн боловсролгүй, зөвлөлтийн улс төрийн сургаалыг бодох юмгүй өнгөцхөн хүлээн авсан хамгийн доод давхаргын албан тушаалтнууд тодрон гарч ирлээ. 1929-1931 онуудад "феодалын хөрөнгө" гэгчийг төрөөс хураан авав. Энэхүү хөрөнгө хураалт нийгэмд хичнээн гүнзгий цохилт болсныг хураах хөрөнгөний тогтоосон хэмжээнээс нь олж харж болно. Хувьдаа арваас илүү тооны адуу, далаас илүү тооны хоньтой хүний хөрөнгийг нь хураах албатай "феодалын эгнээнд" жагсаан оруулсан байдаг. Энэхүү арга хэмжээний гайгаар иргэдийн мал хөрөнгийг хамгийн бага хэмжээнд ортол огцом тэгшитгэж өгсөн билээ.

1937-1940 онуудад сталинист аллага хядлагын уршгаар тайж язгууртан, лам хуваргууд, мөн түүнчлэн МАХН-ын олон идэвхтэн элитүүдийг системтэйгээр устгаж үгүй хийсэн байна. Ингээд монголын нийгмийг үндсэнд нь хоёр бүлэг болгон ангилж болохоор болжээ: нүүдэлчин малчид ба суурин амьдралд орсон МАХН-ын эрх мэдэлтнүүд. Иргэдийн цөөнхийг бүрдүүлдэг гар урлал ба ахуй үйлчилгээний салбарынхан бараг ач холбогдолгүй шахуу нийгмийн бүлэг болон үлдсэн билээ.

Шашныг сөнөөн устгах аян дайны үрээр буддын соёл дахь үнэлэмж баримжааг зөвлөлтийн соёлоор орлуулан сольж байх тэр үе мөчид кирилл үсгийг нэвтрүүлэх тухай Сайд нарын зөвлөлийн тогтоол (1941) гарснаар монголчуудыг төв азийн буддын соёлын хүрээнээс нь таслан хөндийрүүлэх алхам биелэлээ олсон байна. МАХН-ын X Их Хурлаас (1940) хойш монголын нийгмийг алхам алхмаар зөвлөлтжүүлсээр байлаа. Сталины алан хядлагын үеэр монголын хуучин элитийг устган сөнөөсөн тул ахархан хугацааны дотор албан тушаалтны шинэ элитийг үүсгэн бий болгох шаардлага урган гарав. Эдгээр шинэ албан тушаалтнууд болон шинэ сэхээтнүүдийг (хуучин байсан эрдэмтэд болон сэхээтэн лам нарыг ч мөн устган үгүй хийсэн юм) ЗХУ ба Монгол оронд сурган бэлтгэх ажил (гэхдээ зөвлөлтийн сургалтын хөтөлбөрийн дагуу) өрнөв. Зөвлөлтийн сургагч нар МАХН болон түүний боловсон хүчинд марксист-ленинист үзэл суртлыг гаднаас нь тулган сургасан нь зохиогүй малгай

өмсгөсөнтэй зүйрлэхээр явдал болсон юм. Ямар ч атугай элитийг нь үзэл суртлаар зэвсэглэсэн явдал нь монголын нийгмийг зөвлөлтийн үлгэр жишээгээр өөрчлөн байгуулах зорилготой уялдаатай асуудал мөн.

Нийгмийг зөвлөлтжүүлэх асуудал нь тухайн нийгмийн дотор ноёрхож байсан нүүдэлчний бүтцийн улмаас ихээхэн бэрхшээлтэй тулгарсан билээ. Ингээд зөвлөхүүд монголчуудыг удаан хугацааны турш суурин амьдрал руу аажмаар шилжүүлэн оруулах боломжийг эрэлхийлэх болов. Тэдний дүгнэлт ёсоор энэхүү алхмыг монголын нийгмийн эдийн засгийн бааз суурийг өөрчлөн, монголын дотоод дахь эдийн засгийн өсөлтийнх нь хүчээр хэрэгжүүлэх боломжтой ажээ. МАХН-аас 1957/58 оны үеэс хэрэгжүүлсэн мал сүргийг нийгэмчлэх ажиллагаа нь хэдийгээр 1929/31 оны үеийн хувийн өмчтөнийг хүчээр хамтралжуулсан "зүүнтний нугалаа"-ны хэмжээнд хүрээгүй хэдий ч дийлэнх тохиолдолд хуулийн болон материаллаг дарамтын дор малчдын хүсэл зоригийг харгалзалгүй хүчээр тулгасан үйлдэл болж өнгөрсөн юм. Шинээр байгуулагдсан нэгдлүүд нь мал аж ахуйг алхам алхмаар хагас нүүдлийн хэлбэрт оруулсан бүтэц байлаа.

Монголын нийгэмд гарсан чанарын гүнзгий өөрчлөлт нь ЭЗХТЗ (Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл)-ийн цогцолбор хөтөлбөрийн (1971) хүрээнд хийгдсэн аж үйлдвэржүүлэлт бөгөөд түүний үндсэн нөхцөл ба түүнээс урган гарсан үр дагавар нь монголын нийгэм дэх нэлээд гүнзгийрсэн хотжилтын үйл явц юм. 1956 онд нийт хүн амын дийлэнх буюу 78,4% нь хөдөөний иргэд байсан бол 1979 онд нийт хүн амын 51,2% нь хэдийнээ хот суурин газрын оршин суугчид болжээ.

Аж үйлдвэржүүлэлтийн үр дүнд үндэсний нийт үйлдвэрлэлд аж үйлдвэрийн эзлэх хувийн жин байнга өсөн нэмэгдсээр байлаа. 1970 онд аж үйлдвэрлэл 22,6% (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 25,3%) байсан бол 1980 онд 29,3% (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 15,0%) болтлоо өсөн нэмэгдсэн байдаг.

Аж үйлдвэржүүлэлт нь нийгмийн бүтцийг нэлээд өөрчиллөө. Монгол оронд ажилчин анги үүсэн бий болж, тэдгээрийн дийлэнх нь Улаанбаатар-Дархан-Эрдэнэт гэсэн гурван хотуудын үйлдвэрүүдэд төвлөрөв. Нийт ажиллагчдын тоонд харьцуулбал ажилчдын тоо 1990 оныг хүртэл жилээс жилд тогтмол өсөн нэмэгдсээр байжээ. 1940 онд тус орны аж үйлдвэрийн салбар нийт 9.800 ажилчинтай байсан бол 1990 оныг хүртэл ажилчдын тоо 79.400 болтлоо нэмэгдсэн байна.¹

Монгол орны хөгжлийн өвөрмөц замыг ажиглан харвал ажилчин анги нь цэвэр суурин нөхцөл байдлын дор хөгжих ёстой хамгийн анхны нийгмийн бүлэг юм. Ажилчдын дийлэнх нь хөдөө орон нутагт төрж өссөн ба хожим нь хотын ажилчдын суурин руу шилжин ирцгээсэн байдаг. Энд ирээд тэд богино хугацааны дотор технологийн үйл явц руу татагдан орж, Монгол оронд урьд өмнө хэзээ ч байгаагүй боловсролоор хүмүүжсэн билээ.

Онцгой ач холбогдолтой зүйл бол шинэ сэхээтний давхарга үүсэн бий болсон явдал. Орон даяар засаг захиргаа, эрүүл ахуй болон боловсролын салбарын системүүд бий болсноор, мөн аж үйлдвэржилт гүнзгийрэн хөгжсөнөөр эдгээр салбарт шаардагдах мэргэжлийн бүлгүүдийг бий болгох нь зайлшгүй билээ. 1941-1960 онуудад тусгай ба дээд боловсролтой 18.000 мэргэжилтэн

¹ Х. Гүндсамбуу, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун), Улаанбаатар 2002, 282-р тал.

бэлтгэв. Тэдгээрийн 95,6%-д нь Монголд, үлдсэн 4,4%-д нь ЗХУ-д боловсрол олгов. 1960 оны үед дээд сургуульд төгсөгчдийн 28,5% нь материаллаг үйлдвэрлэл дээр ажиллаж байлаа.¹ Мөн түүнчлэн монголын сэхээтнүүдийн дийлэнх нь анхнаасаа суурин газруудад ажиллаж амьдарч ирлээ.

Аж үйлдвэржүүлэлтийн үр дүнд олон тооны инженер-техникийн ажилтнууд, мөн эдийн засгийн удирдах ажилтнуудыг хурдан хугацаанд сургаж бэлтгэх шаардлага урган гарсан юм. Монгол орон ЭЗХТЗ-ийн гишүүн болсноор (1962) монголын залуус хуучин социалист орнуудад улам олноороо суралцах болжээ. Эдгээр залуус ингээд өөрийн орон болон өнөөг хүртэл мэддэг байсан ЗХУ-аас үндсээрээ ялгаатай өөр бусад социалист орнуудын нийгэм соёлтой танилцаж эхэллээ. Эдгээр орнуудыг Монгол ба ЗХУ-тай харьцуулбал амьдралын төвшин нь илэрхий өндөр, социализмыг нэлээд либераль маягаар ойлгон авч үздэг, илүү эрх чөлөөтэй, дээд сургуулиудад нь шинжлэх ухааны төвшин өндөр байдаг зэрэг ялгаануудыг оюутан залуус ойлгож мэдсэн байна. Эдгээр сэхээтнүүдээр дамжин Монгол оронд улс төрийн шинэ ойлголт, ухаарал орж ирсэн билээ. Тэд өөрийн орны социализмын загварыг шүүмжлэлтэй авч үзэн, дангаар ноёрхож байсан МАХН-ын улс төрийн хүсэл шаардлагатай зөрчилдөж эхэлсэн юм. Намын удирдлага энэхүү санаа бодлыг тууштай нухчин дарсаар ирэв. Өөрийн гэсэн ойлголт, эсвэл сэхээтний төлөөллөөс гарсан аливаа шүүмжлэлтэй алхмуудыг үе шат дараалсан кампанит ажлын хүрээнд дарсаар ирсэн. МАХН-ын нэлээд нөлөөтэй Хянан Шалгах Комисс нь сэхээтнүүдийг намын гишүүдийн 20%-иас хэтрүүлэхгүй явдалд анхаарлаа тавьсан юм.

Монголын нийгэм нь аж үйлдвэржилт харьцангуй хурдтайгаар гүнзгийрэн хөгжих тутам МАХН өөрийн ноёрхлын аргаа арай илүү соёлтой болгон, түүний дотор намын эрх мэдэлтнүүдээ чанарын хувьд өөрчлөх шаардлагатай тулгарлаа. Намын өндөр албан тушаалд дэвшихийн тулд мэргэжлийн боловсролтой байх ба энэхүү мэргэжлийн боловсрол дээрээ улс төрийн боловсрол эзэмшсэн байх ёстой ажээ. Социалист нийгэмд соёлжуулах /иргэншүүлэх нөөц бололцоо гэгч байсан бөгөөд түүний үндсэн нөхцөл нь зайлшгүй эдийн засгийн өсөлт байх ёстой ажээ. Монгол улсын эдийн засгийн өсөлт нь ЭЗХТЗ-ийн орнуудын санхүүгийн тусламж ба хөрөнгө оруулалтын улмаас сайндаа л "зээлдсэн" хиймэл өсөлт байсан гэдэг нь 80-иад оны эхэн үеэс тодорхой болсон юм. Тэр үед ЗХУ ба социалист бусад орнуудын эдийн засаг дахь хомсдлын үрээр ЭЗХТН-аас үзүүлэх туслалцаа буурмагц Монголын эдийн засгийн хямрал гүнзгийрсэн явдал үүнийг гэрчилнэ. 1970-1980 онуудад Монгол улсын орлого хоёр дахин өссөн байхад (1970: 1,965 тэрбум төгрөг, 1980: 4,073 тэрбум төгрөг), 1980 оны үеэс энэхүү өсөлт зогсолтод орж эхлэв. Эдийн засгийн өсөлт нэлээд уруудаж, эдийн засгийн хөгжил урагш ахисангүй. Гэтэл энэ хугацаанд хүн ам огцом өссөн байдаг. 1970 онд нийт 1,2305 сая хүн амтай байсан бол 1980 онд энэ тоо 1,6397 сая хүн амтай болтлоо нэмэгдэв.² Хүн амыг хамгийн наад захын үндсэн хэрэглээгээр л хангаж чадаж байлаа. Иргэдийн дургүйцэл өслөө. Энэхүү эсэргүүцэл нийгмийн бүхий л давхрагыг хамран давалгаалав. МАХН-ын удирдах албан тушаалтнуудаас зарим нь энэхүү үйл явцыг гагцхүү дарангуйллын хүч хэрэглэх аргаар зохицуулах боломжгүйг ойлгов.

Монгол ба перестройка

МАХН-ын удирдах шатны зарим албан тушаалтнууд намын удирдлагад өөрчлөлт оруулснаар бүх зүйлийг өөрчилнө гэсэн итгэлтэй байв. Нам ба төрийн удирдагч Ю. Цэдэнбал нэлээд хэдэн жилийн өмнөөс сэтгэцийн мартамхай

¹ Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх, Улаанбаатар 1987, 26-р тал.

² Народное Хозяйство, Улаанбаатар 1984.

өвчинд нэрвэгдсэний хажуугаар түүний орос гэргий Улс Төрийн Товчооны үйл ажиллагаанд улам хүчтэй нөлөө үзүүлэх болов. Ингээд 1984 онд зөвлөлтийн талын дэмжлэгтэй гэдэг "ордны бослого" гарч Ю. Цэдэнбал ба түүний хамгийн ойр дотны зарим сайд нарыг огцруулав.

МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга байсны хувьд Ж. Батмөнх нам ба төрийн залуурыг гартаа авлаа. Намын шинэ удирдлага М. С. Горбачевийн ЗХУ дахь социалист нийгмийг хямралаас гаргах зорилго агуулсан *перестройка*-гийн үзэл санааг дараагийн жилүүдэд нь үг дуугүй даган хэрэгжүүлэх зам руу орлоо.

Ж. Батмөнх нам ба төрийн толгойд гармагц монголын улс төрийн удирдлагад анх удаа боловсон хүчний сэлгээ хийгдлээ. 1985-1990 онуудад төрийн ахмад удирдлагуудын дийлэнх нь албан тушаалаасаа огцорлоо.¹ МАХН-ын аппаратад харин ялангуяа дунд шатны удирдлагад залгамж үеийнхнээр сэлгээ хийгээд тэдгээр нь 1990 оны дараахан Төв Хороо, Улс Төрийн Товчоонд орцгоосон байна.

Хуучин дарга нарыг бодвол эдгээр шинэ удирдлагууд ажлаа илүү мэддэг, тэдгээрийн удирдаж ирсэн социалист нийгмийн алдаа мэдгийг ухамсарлан ойлгох чадвар илүүтэй нь харагдаж байжээ. Ялангуяа эдийн засгийн удирдагчид хамгийн чухалд тооцогдож байсан нь намын шинэ удирдлага өөрсдийн үйл ажиллагаандаа эдийн засгийн асуудлыг нэн тэргүүнд тавьж байсны жишээ болж байна.

Гэхдээ МАХН-ын удирдлага энэ цаг үед огт цоо шинэ үндсэн санаа гаргаж ирж чадаагүй. Тэд социалист нийгмийг өөрсдийн төсөөллөөр илүү хүмүүнлэг, эдийн засгийн системийг нь илүү үр өгөөжтэй болгон өөрчлөхийг санаархаж байв. Тэр үедээ л энэ нь чамлахааргүй сэтгэлгээ байжээ. Гэсэн хэдий ч тэд өөрчлөн байгуулалт хийх үзэл баримтлалгүй байлаа. Эдийн засгийн зарим нэг салбарыг хувьчлахаас (хөдөө аж ахуйн хувьд хэсэг хувьчлал) өөр асуудал тухайн үеийн удирдлагын төсөөлөлд ч багтахгүй байлаа. Иймээс тэд эдийн засгийн нарийн хяналт, аривлан хэмнэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг чанд сахилгажуулах, үйлдвэрийн газрын удирдлагыг илүү сайн сургах, мөн түүнээс гадна хүнсний хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүдийн хувийн хэвшлийн санаачилгуудыг хагас хугас дэмжих зам руу орлоо.² Гэхдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг хэвээр нь авч үлдсэний улмаас эдийн засгийн шинэчлэлт амжилт үзүүлсэнгүй. Үнэн хэрэгтээ эдгээр шинэчлэлүүд мухардалд орж, ямар ч үр дүнд хүрсэнгүй.

МАХН-ын удирдлага эдийн засгийн аливаа өөрчлөлт нь улс төрийн хүлээс, төрийн марксист үзэл суртлыг зайлуулж байж биелэлээ олно гэдгийг ойлгож мэдрэх ёстой байжээ. Шинээр гарч ирсэн тэрхүү удирдагч нар мөн л өмнөх улс төрийн системийнхээ бүтээгдэхүүнүүд байсан тул тэр системдээ дасчихсан, төсөөллийнхөө хязгаарлагдмал ертөнцөөс халин гарч чадахгүй нь мэдээж билээ. Тэдгээрийн дотроос цөөн хэд нь л энэ байдал МАХН-ын эрх мэдлийн монополийг хямруулаад зогсохгүй энэхүү намыг өөрийг нь замаас зайлуулахад хүргэнэ гэж ойлгож байв. Үүний зэрэгцээ нэгэн асуудал босч ирлээ. Олон арван жилийн турш улс төрийн ганц тулгуур үзэл баримтлал байх ёстой хэмээн ойлгож заншсан хүмүүсийн хувьд хуучин үзэл баримтлалыг ямар шинэ

¹ Ардын Их Хурлын дарга хоёр удаа, түүний орлогч дарга нэг удаа, Сайд нарын Зөвлөлийн дарга нэг удаа, түүний орлогч дарга зургаан удаа, янз бүрийн яамны сайд хорин таван удаа, янз бүрийн яамны орлогч сайд гучин гурван удаа, Улсын Хорооны дарга арван гурван удаа, тэрний орлогч дарга хорин зургаан удаа. У. Б. Баркманн, 1985-1990 он хүртэл БНМАУ-ын улс төрийн зүтгэлтнүүд, төрийн зүтгэлтнүүдийн хэсэг (хэвлэгдээгүй).

² БНМАУ-ын хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилготой программ, Үнэн, 1985 оны 6-р сарын 23.

үзлээр орлуулан сольж болох, мөн тэр нь илүү сайн байж чадах эсэх гэсэн эргэлзээ рүү орж орхив.

1988 онд МАХН-ын ТХ-ны 5-р бүгд хурал хуралдав. Хуралд оролцогчдын дийлэнх нь монголын эдийн засагт бага хэмжээний засвар оруулах нь байдлыг бүхлээр нь сайжруулж чадахгүй гэдгийг ил тодоор хүлээн зөвшөөрсөн байна. Нэлээд өргөн хүрээний, түүн дундаа улс төрийн хүрээнд өөрчлөлт хийх шаардлагатай болжээ. Бүгд хурлын шийдвэрээс дурьдвал: "Эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулашгүй зорилт болж байна."¹ Хуралд оролцогчид төр ба олон нийтийн байгууллагыг "ардчилах", үүний тулд марксизм/ленинизмийн үзэл суртлын өөрчлөн байгуулах хүчин чадлыг гарган ирж боловсруулах" зайлшгүй шаардлага байгааг тодорхойлов. МАХН нь хэрэг дээрээ энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн тулд шинэ боловсон хүчнээр сэлбэгдэх ёстой байжээ. Гэхдээ 5-р бүгд хурлын шийдвэр, түүнээс улбаалан баримтлах бодлогыг МАХН-ын удирдлагууд хэдийгээр хүссэн хэдий ч ямар ч үр өгөөжгүй хоосон өнгөрсөн юм. Тэд улс төрийн бодлогын хөшүүн хүрээ ба урагш ахихаа байсан системийг бага зэрэг зөөлрүүлж чадсан. "Ил тод байдал" нэрийн дор улс төрийн ямар ч санаа бодлоо иргэд гаргаж хэлэх боломжтой боллоо. МАХН-ын Улс Төрийн Товчоо 1988 оны 11-р сарын 16-ны өдрийн тогтоолоор 30/40-өөд оны үеийн хэлмэгдүүлэлтийн тухай асуудлыг хөндөж тавихад анх удаа МАХН-ын улс төрийн хариуцлагын тухай шүүмжлэлтэй асуултуудыг ил тодоор хэлэлцэв. МАХН-ын удирдлага энэ үед хуримтлагдаад байсан асуудлуудын өмнө мухардалд орж, өрнөж байгаа маргааны үндсэн сэвийг задлан шинжлэх, дүгнэлт гаргах байтугай аливаа үйлдлийг хэрэгжүүлэх чадваргүй болох нь улам ойлгомжтой боллоо. Ийм нөхцөл байдлын дор Монгол улсын дотоодын нөхцөл байдалд нэгэн гадаад хүчин зүйл шийдвэрлэх нөлөө үзүүлжээ.

ЗХУ 1989 онд БНХАУ-тай хэвийн сайн харилцаа тогтоов. Монгол улс ингээд Зөвлөлтийн улс төрчдийн хувьд Хятад, Оросын хооронд орших стратегийн ач холбогдолтой буферийн бүс байхаа больжээ. Мөн энэ мөчид ЗХУ-д өрнөж байгаа улс төрийн үйл явцыг хүчирхэг ЗХУКН хяналтаасаа алдлаа. Энэ хоёр хүчин зүйлийн улмаас ЗХУ монголын нийгмийг бүхлээр нь хамарсан хяналтаа сулруулж, Монгол улс төр ба эдийн засгийн үйл ажиллагаагаа алхам алхмаар буурууллаа. Монголын талаар баримталдаг зөвлөлтийн бодлого анх удаа ингэж өөрчлөгдсөний үр дүнд МАХН стратегийн шийдвэрүүдийг бие даан гаргах шаардлагатай болов. Социализмын үед эдийн засаг, улс төрийн бүхий л шийдвэрийг их бага хэмжээгээр Москва гаргадаг байсан хэдий ч нам өөрийн гэсэн үзэл баримтлалаа боловсруулах чадвартай нь харагдаж байсан ч цаг хугацаа өнгөрөх тутам энэхүү чадвараа алдсаар байв.

Зөвлөлтийн эдийн засгийн тусламжийн чухал хэсгүүд хорогдсоор байсан нь монголын эдийн засгийн хямралыг гүнзгийрүүллээ. Ард иргэдийн амьдралын төвшин уруудав. Социализмын нөхцөл байдал ноёрхож байгаа цагт гарах арга замгүй энэхүү хямралыг МАХН зохицуулах ёстой байлаа. Зүүн Европоос зүүний орнуудад улс төрийн эргэлт гарч байгаа дохио ирсээр байлаа. Иймээс энэхүү хөгжилтэй холбоотойгоор 1989 оноос хойш Монгол оронд ч мөн адил улс төрийн сөрөг хүчин бий болох таатай нөхцлүүд бий болсон билээ.

Сөрөг хүчин

Сөрөг хүчин анх үүсэхдээ хэд хэдэн үе шатыг дамжжээ. Иргэдийн дийлэнхийг хамарч байсан тухайн үеийн улс төрийн сэдэвтэй маргаанууд сөрөг хүчин үүсэн бий болох тааламжтай орчинг бүрдүүлсэн юм. 1989 онд сэхээтнүүд тэр үеийн байдал, мөн хямралаас хэрхэн гарах талаар маргалдан ярилцдаг

¹ Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V Бүгд Хурал, Улаанбаатар 1988, 5-р тал.

анхны дугуйланг Улаанбаатар хотноо байгуулав. Жишээлбэл ҮЭ-ийн соёлын төв ордонд "Орчлон" нэртэй нууц дугуйлан ажиллаж байв. Мөн бусад газруудад "Шинэ үе", маргалдааны клуб "Ертөнц", "Залуу эдийн засагчдын клуб" зэрэг олон бүлгүүд үйл ажиллагаагаа явуулж байв. Багшийн дээд сургуулийн оюутнууд "Цагийн толь" нэртэй нууц сонин гаргаж цаг үеийн асуудлуудын талаар бичдэг байв. Эдгээр дугуйлангуудын цугларалт тогтмол бус, нөгөө талаас зохион байгуулалтын болон мөрийн хөтөлбөр ч байсангүй. Мөн нууц хуйвалдааны шинжтэй байхаас аргагүй байсан. Учир нь тэр үед цагийн байдал яаж өрнөх нь тодорхойгүй байсан, нөгөө талаас НАХЯ ийм маягийн үйл ажиллагааг тагнаж чагнадаг байжээ.

Эдгээр дугуйлангуудаас богино хугацааны дотор сөрөг хүчний хөдөлгөөнүүд урган гарав. 1988 оны 12-р сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо Монголын Ардчилсан Холбоо (МоАХ) үүсгэн байгуулагдсан ба удалгүй энэ холбоо сөрөг хүчний дотор үйл ажиллагааг нь удирдан зангидах байр суурийг эзэлж чадсан болно. 1990 оны 1, 2-р саруудад өөр хөдөлгөөнүүд бий болжээ. Ардчилсан Социализмын Хөдөлгөөн (01-р сарын 04), Шинэ Дэвшилт Холбоо (01-р сарын 19), Эв Нэгдлийн Холбоо (02-р сарын 10) тус тус байгуулагдав. Сүүлийн нэрлэсэн хоёр хөдөлгөөн 1990 оны 02-р сарын 16 (17)-ны өдөр хоорондоо нэгдэж Шинэ Дэвшлийн Холбоо байгуулсныг ажиглахад сөрөг хүчин бий болсон анхны мөчөөсөө л эхлээд байгаа хүчин чадлаа нэгтгэн төвлөрүүлэх сонирхолтой байсныг илтгэж байна. 1990 оны 1, 2-р саруудад сөрөг хүчний эдгээр хөдөлгөөнүүдээс улс төрийн сөрөг хүчний намууд төрөн гарав. 1990 оны 02-р сарын 18-ны өдөр Монголын Ардчилсан Нам (МоАН), 03-р сарын 9-ний өдөр Монголын Ногоон Нам (МНН), 03-р сарын 11-ний өдөр Монголын Үндэсний Дэвшлийн Нам (МҮДН) 03-р сард Монголын Чөлөөт Хөдөлмөрийн Нам (МЧХН) мөн 1990 оны 03-р сарын 31-ний өдөр Монголын Социал Демократ Нам (МСДН) тус тус байгуулагдлаа.

Улс төрийн намууд хурдан хугацаанд тууштайгаар бий болсон нь эргэлзээгүй зөв зам руугаа орж эхэлсэн алхам мөн. Зүүн европын орнуудын туршлагаас харахад тэндхийн иргэний хөдөлгөөнүүд үзэл суртлын байр сууриа илэрхийлсэн ч гэсэн ерөнхийдөө эрээвэр хураавар, тогтворгүй учраас хурдан тарж бутарсаар байсан билээ. Монгол орон Польш, Унгар, Зүүн Герман мэтийн орнуудын адил социализмын өмнөх үе шатандаа улс төрийн намууд байсан туршлагагүй учраас өмнө нь байсан намууд дээрээ түшиглэх гэсэн ойлголт байгаагүй. Иймээс богино хугацааны дотор олон улс төрийн намууд байгуулан МАХН-ын адил тэгш эрх бүхий, улс төрийн хувьд альтернатив хүчин болгож хөгжүүлэх явдал нэн чухал байв.

МоАН, МСДН ба МЧХН нь нэлээд олон тооны гишүүдтэй учраас эдгээр намууд бусад намуудтай харьцуулахад анхнаасаа л улс төрийн амьдралд нөлөөлөх илүү өргөн боломжтой байлаа. Шинээр бий болсон намууд ардчилал, улс төрийн олон ургальч үзэл, мөн хэсэг хугацаанд бодол болсны дараа чөлөөт зах зээлийн харилцааг бий болгох үзэл баримтлалыг дэвшүүлсэн билээ. МоАН, МСДН, МЧХН-ын анхны их хурлуудын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг ажиглахад эдгээр намын эгнээнд гол төлөв сэхээтнүүд, ажилчид, өөрөөр хэлбэл хот суурин газрын амьдралаар хүмүүжсэн хүмүүс голлож байлаа. Эдгээр намууд БНМАУ-ын хүн амын хагас байсан малчид, өөрөөр хэлбэл хөдөө орон нутгийн иргэдийг бараг төлөөлөхгүй байх мэт.

МоАН, МСДН, МЧХН-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

Нам	Нийт төлөөлөгчид	Үүнээс хот суурин газраас (%)	Үүнээс хөдөө орон нутгаас (%)	Үүнээс сэхээтнүүд (%)	Үүнээс ажилчид (%)	Үүнээс малчид (%)
-----	---------------------	---	---	-----------------------------	--------------------------	-------------------------

MoAH ¹	865	76,99	23,01	53,00	40,00	7,0
МCДН ²	467	91,14	8,60	75,37	17,55	?
МOДН ³	648	90,27	9,73	43,20	?	2,0

Сөрөг хүчний улс төрийн намууд байгуулагдаж, өөрсдийн бие даасан бодлогыг илэрхийлэн томьёолох үйл явц нь МАХН эрх мэдэл, нэр нөлөөгөө алдах үйл явцыг араасаа дагуулан явж ирлээ. Сөрөг хүчний үзүүлсэн дарамтын үр дүнд МАХН-ын Улс Төрийн Товчоо огцров. МАХН-ын Төв Хорооны 8-р Бүгд Хурлын оролцогчид БНМАУ-ын Үндсэн хуулийн оршил ба 82-р заалт болох МАХН-ын ганцаар ноёрхох заалтаас албан ёсоор татгалзав.⁴ Гэтэл МАХН-ын Онц Их Хурал (1990 оны 4-р сарын 10-13)-аас тус нам шинэ нөхцөл байдлын дор цаашдаа оршин тогтнох боломжийг бүрдүүлсэн намын зохион байгуулалтын үндсэн суурийг батлаж гаргав. Өмнө нь байсан Улс Төрийн Товчооны оронд удирдах зөвлөлийг байгуулж, намын төв аппаратын ажилтнуудыг 44%-иар хорогдууллаа.

Сөрөг хүчний зүгээс монголын нам, засгийн удирдлагад хандан намын тухай хууль батлан гаргахыг шаардав. Энэхүү хууль нэн чухал байсан бөгөөд учир нь сөрөг хүчний намууд анх байгуулагдсан цагаасаа хойш оршин тогтнох ба үйл ажиллагаагаа явуулах ямар ч эрх зүйн үндэсгүй байсаар байв. Парламент болох Ардын Их Хурал 1990 оны 05-р сарын 10-ны өдөр "БНМАУ-ын улс төрийн намуудын тухай хууль"-ийг батлан гаргажээ. Энэхүү хууль өнөөг хүртэл мөрдөгдөж байгаа бөгөөд зарим нэг зүйлийг өөрчилсөн энэ хууль улс төрийн намуудыг хуулийн хамгаалалтанд авчээ. Тус хууль нь Үндсэн Хуулийн хүрээнд, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчихгүйгээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулах улс төрийн намуудыг үүсгэн байгуулахыг зөвшөөрсөн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарилалтын зарчмаар зохион байгуулагдаж өөрөө өөрийгөө санхүүжүүлэн авч явах ёстой болохыг зааж өгсөн байна. Улс төрийн намууд БНМАУ-ын Дээд Шүүхэд бүртгүүлэх ёстой. Намын дарга бүртгүүлэх өргөдлөө Дээд Шүүхэд гардуулна. Өргөдлийн хамт намын нэр, намын хаяг, намын зохион байгуулалт ба бүтцийн тухай мэдээлэл, намын дүрэм ба хөтөлбөр, намын хөрөнгийн тухай мэдээлэл түүнчлэн 801-аас цөөнгүй тооны гишүүдтэй гэсэн баталгаа (гишүүдийн овог, нэр, нас) мэдээллүүдийг хавсруулан өгнө. Сайтар шалгасны дараа тухайн улс төрийн намыг бүртгэж авна. Энэ цагаас хойш тус нам хуулийн этгээдийн эрхийн төлөөлөл болж хувирна.

Сөрөг хүчний намуудын хувьд тэр үед өөрийн гэсэн санхүүгийн хөрөнгөтэй болох нь тэдгээрийн оршин тогтнолыг шийдвэрлэх зангилаа асуудал байв. Хуулийн дагуу намын хөрөнгө "гишүүдийн татвар ба хандив, тус намыг дэмжигч монголын иргэд ба албан байгууллагуудын хандив, намын үйл ажиллагаатай холбоотой бусад орлого, өөрийн санхүүгийн үйл ажиллагаанаас олсон бусад орлогууд" байна гэж заасан байдаг. Цаашилбал уг хуулинд зааснаар: "Улс төрийн нам нь Монгол Улсын хуулийн дагуу аль нэг нам, эсвэл гадаадын иргэдээс хандив авч болно. Хандивын хэмжээг олон нийтэд ил тод зарлана."⁵ МАХН-ын Их Хурал дахь бүлэг намын тухай хууль 1921 онд МАХН

¹ Х. Дашзэвэг, МУАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996), Улаанбаатар 1990.

² Монголын Социал-Демократ Намын Анхдугаар Их Хурал, Улаанбаатар 1990, 3-4-р тал.

³ Монгол Үндэсний Дэвшилтийн Намын Анхдугаар Их Хурал, Улаанбаатар 1990, 4-5-р тал.

⁴ "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог Монгол Ардын Хувьсгалт Нам мөн." (Үндсэн хуулийн оршилд үзмүү) "Улсын ба хөдөлмөрчдийн олон түмний бусад бүх байгууллагын манлайлагч бөгөөд жолоодогч Монгол Ардын Хувьсгалт Намд ажилчид, хоршоолсон хөдөлмөрчид, хөдөлмөрч сэхээтний эгнээнээс шалгарсан хамгийн идэвхтэй, ухамсартай иргэд эвлэлдэн нэгдэнэ." (Монгол Улсын Үндсэн Хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд 1924-1992 он, Улаанбаатар 1998 он, 44, 68-р тал)

⁵ Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль, 34-р тал.

үүсгэн байгуулагдсан явдлыг харгалзан үзэх ёстой хэмээн шаардав. Иймээс хууль тогтоогч нар үүнийг харгалзан үзэж дараахь нэмэлтийг оруулав: "6-р бүлэг. МАХН-ыг энэ хуулийн дагуу бүртгэхэд тэр нь хуулийн этгээдийн эрхийг залгамжлан хэрэгжүүлнэ." гэжээ.¹ Намуудын тухай хууль хүчин төгөлдөр болон батлагдсанаас хоёр цагийн дараа МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Г. Очирбат өөрийн намыг Дээд Шүүхэд бүртгүүлсэн байна. Г. Очирбатын өргөдөл: "Засгийн газрыг бүрдүүлж байгаа намын хувьд МАХН манай улсын хуулийг хүндлэн дээдлэх зарчмын үүднээс хандвал тус намыг анхлан үүсгэн байгуулагдсан өдөр болох 1921 оны 3-р сарын 1-ний өдрөөс эхлэн албан ёсоор бүртгүүлсэнд тооцох нь зөв гэж үзлээ" гэжээ.²

Улс төрийн намууд дараахь дарааллаар бүртгүүлсэн байна:

(a) Нам	(b) МАХН	МҮДН	МЧХН	МоАН	МСДН	МНН
Гишүүдийн тоо	94.000	1.800	809	7.200	2.900	806
Бүртгүүлсэн огноо	1990.5.16	?	1990.5.22	1990.5.24	1990.5.25	1990.5.26

(гишүүдийн тоог намуудын өөрсдийнх нь өгсөн мэдээллээр нийтлэв)

Сөрөг хүчний намууд ингээд хуулийн хамгаалалтанд багтан орлоо. Улс төрийн намуудыг социалист төрийн хуулийн хүрээнд хүчин төгөлдөр болгосон бол дараагийн алхам нь ардчилсан сонгууль явуулсны үр дүнд төр ба нийгмийг өөрчлөх өөрчлөлтийг эхлүүлэх явдал байлаа.

1990 оны Ардын Их Хурлыг сонгох анхны чөлөөт сонгууль

МоАХ-оор удирдуулсан сөрөг хүчин МАХН-ын удирдлагад багцалсан улс төрийн шаардлагуудыг удаа дараалан тавьж байлаа. Эдгээр шаардлагуудын дотор улс төрийн бүхий л хүчнүүдийг тэгш эрхтэй оролцуулсан шилжилтийн шинж чанартай Ардын Түр Хурал байгуулах асуудал оров. Учир нь сөрөг хүчний үзэж байгаагаар Ардын Их Хурал ардчилсан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй, сонгогдоогүй ажээ. Ардын Түр Хурал нь БНМАУ-ын шинэ Үндсэн Хууль, мөн улсын сонгуулийн хуулийг батлах ёстой ажээ. Энэхүү санал ёсоор Ардын Их Хурал тарж, ардчилсан шинэ сонгуулиар шинэ парламент сонгогдон гарч ирэх ёстой юм. МАХН-ын удирдлага энэхүү саналаас удаа дараа татгалзан огт хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Тэдний үндэслэлээр бол энэхүү асуудлыг зөвхөн Үндсэн Хуулийн хүрээнд, зөвхөн шинэ сонгууль явуулж байж л шийдэх ёстой асуудал ажээ.

МоАХ, МоАН ингээд 1990 оны 3-4-р саруудад МАХН-ын удирдлагад дарамт үзүүлэх зорилгоор хэд хэдэн удаа эсэргүүцлийн цуглаан зохион байгуулж өөрсдийн шаардлагаа олон нийтэд хүргэлээ. МАХН-ын удирдлага хэдийгээр өөрийн байр суурин дээр хатуу зогсож байсан хэдий ч шинээр сонгууль явуулах ёстой болж, энэхүү бэлтгэл ажилдаа эрчимтэй орох болов. Зүүн Европ болон ЗХУ-ын байдлыг ажигласнаараа намын удирдлагууд Монгол оронд тун удалгүй зөвхөн шинэчлэл хийгдээд зогсохгүй, харин улс төр, нийгмийн системийн үндсэн өөрчлөлтүүд хийгдэх ёстой нь тун ч тодорхой болсон байлаа. Хэрэв МАХН-ын удирдагчид ухаалаг шийдвэр гаргасан бол тус нам улс төрийн амьдралд удаан хугацаагаар нөлөөлөн оролцох өөрийнхөө боломжийг баталгаажуулан зайлшгүй дайран ирэх улс төрийн шилжилтийн тэр үед эрх мэдэл, нэр нөлөөгөө бараг алдахгүй хадгалан үлдэх үүд хаалга нээгдэнэ хэмээн тэд тооцоолж байлаа. Иймээс хийх ёстой өөрчлөлт нь ялангуяа парламентийн бүтцэд хамаатай бөгөөд сөрөг хүчин зөвхөн таашаагаад зогсохгүй, харин ч

¹ Мөн тэнд, 32-р тал.

² МАХН-ын Төв Хорооны дарга өргөдөл гаргав, *Үнэн*, 1990 оны 5-р сарын 11.

хамтран ажиллахад бэлэн болохоор хэмжээнд парламентийн системд тодорхой хэмжээний ардчилсан өөрчлөлт байх ёстой байв. Сөрөг хүчнийг ямар нэг хэлбэрээр хамтын ажиллагаанд татан оролцуулах явдал бүтэлтэй эсэхээс шалтгаалаад эсэргүүцлийн хөдөлгөөнийг гудамжнаас татан авах боломж нээгдэх байв. МАХН-ын хувьд парламентийн үйл ажиллагаа нь ахархан хугацааны дотор социализмын үеийн ор нэр төдий үйлдэл бус, харин стратегийн чухал ач холбогдолтой асуудал болж хувирсан байна.

1990 оны 05-р сарын 10-ны өдөр Ардын Их Хурлын 9-р хуралдаан эхэллээ. Энэ хуралдаанаас дээр дурьдсан "Улс төрийн намуудын тухай хууль"-ийг батлав. Мөн Улсын Бага Хурлыг (УБХ) хууль тогтоох байнгын ажиллагаатай танхим болгон зарлав. УБХ нь 50 гишүүнтэй байх ба гишүүн бүр сонгогчдын 2%-ийн саналыг (20.000 санал) төлөөлөн суух ажээ. Эдгээр тавин гишүүний 37 нь Ардын Их Хурлын гишүүн, 13 нь Ардын Их Хуралд суудалгүй байхаар тооцоолов. Төлөөлөгчид ерөнхийлөгчийн албан тушаал бий болгохоор тохиролцох ба ерөнхийлөгчийн, дэд ерөнхийлөгчийн, Улсын Бага Хурлын тэргүүлэгч, ерөнхий сайдын, ерөнхий прокурорын, аймаг ба хотын шүүхүүдийн дарга нарын албан тушаалуудыг парламентад суудалтай намуудаас гаргасан санал болон Ардын Их Хурлаас гаргасан санал дээр үндэслэн батлан гаргах юм.

1990 оны 05-р сарын 14-ний өдөр Ардын Их Хурал 1990 оны 7-р сарын 29-ний өдөр парламентийн сонгууль явуулахаар зарлан тунхаглав. Энэхүү сонгууль түүхэн өндөр ач холбогдолтой байсан билээ. Монгол улсын түүхэнд анх удаа чөлөөт, ардчилсан сонгууль явагдаж байгаа ба энэ сонгуулиар нийт 430 сонгуулийн тойрогт нэлээд олон улс төрийн намууд өөрсдийн нэр дэвшигчдээ өрсөлдүүлэх юм. Сөрөг хүчний намууд хөрөнгө хүчний боломж муутай тул өөрийнхээ хэрээр хязгаарлагдмал байдалд өрсөлдөж байсан бол МАХН тэднээс маш ялгаатай, их хөрөнгө зарцуулж өрсөлдөв. МАХН нь орон даяар тархсан бүтэц, зохион байгуулалтын зэрэг олон давуу талтай байсан боловч сөрөг хүчний намууд нийтдээ ердөө л 38 %-ийн санал авч чадсан байдаг. Сонгогчдын санал илэрхий байлаа. Тэд өөрийн нийгэм дэх бодит байдлыг эсэргүүцэн, ардчилал, улс төрийн эргэлтийн төлөө саналаа өгчээ. Тэд улс төрийн шинэ намуудад энэхүү өөрчлөлтийг хийж чадна хэмээн итгэлээ өгсөн байна. Сонгогчдын хувьд шинэ намууд энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлж чадах өөрийн гэсэн тодорхой үзэл баримтлал байхгүй нь ч сонголтод нь нөлөөлсөнгүй.

Улсын их хурал дахь суудлын хуваарилалт¹

Нам	Сонгогчдын өгсөн санал (%)	УИХ дахь суудал	Суудлын эзлэх хувь
МАХН	61,74	357	84,0
МАН	24,33	16	3,8
МҮДН	5,94	5	1,4
МСДН	5,52	4	1,0
МНН	1,24	-	-
МЧХН	1,22	-	-

Сонгуулийн үр дүн сөрөг хүчний хувьд том сургууль боллоо. Эхний ээлжинд тэдний эгнээнд олонд нэр хүндтэй, хүмүүсийг татах чадвартай, суудал авах үнэхээр боломжтой цөөн хэдэн хүн байгааг ойлгов. Сөрөг хүчний улс төрийн хөтөлбөр түүхий байлаа. Сөрөг хүчний олонхи нэр дэвшигчид шинээр улс төрийн тавцанд гарч ирсний улмаас өөрсдийн сонгогчиддоо итгэл үнэмшил

¹ Ж. Гомбожав, Н. Жанцан, Үндсэн Хууль бүтсэн төгчоон, Улаанбаатар 2001, 13-р тал.

төрүүлэхээр элч мэдээ илгээж чадаагүй ажээ. Сөрөг хүчин хүн хүчээр дутмаг учраас 430 тойрогт бүгдэд нь нэр дэвшүүлэх бололцоогүй байв.

Сонгуулийн дараахь цаг үед ямар үйл ажиллагаа явуулах нь тэдний хувьд ойлгомжтой болж ирлээ. Тэд эхний ээлжинд улс төрийн тодорхой мөрийн хөтөлбөр боловсруулан, намын дотсод бүтцийн хувьд зохион байгуулалтыг бэхжүүлэх ажил руу шамдан оров. Мөн юуны түрүүнд намынхаа гишүүдийн анхан шатны бааз суурийг баталгаатай болгон түүнд хамааралтай зохион байгуулалтын бүтцийг бий болгох ёстой байв. Дараагийн сонгуулийг угтан сөрөг хүчнийхэн өөр хоорондоо хамтран сонгуулийн холбоотнууд болон харилцан ойлголцох асуудал хэрэгтэй болов. Ийнхүү намууд эвсэл болж орох асуудал МСДН-аас бусдынх нь хувьд намын хөтөлбөр нь ойролцоо тул хялбар байлаа. Сөрөг хүчний намууд сонгуулийн олон тойрог (нийтдээ 430 суудалтай) болон нэр дэвшигчдийн тоог нэлээд хэмжээгээр цөөлөхийн төлөө ажиллаж эхлэв. Үүний тулд сонгуулийн шинэ хууль гаргах нь зайлшгүй байсан юм. Иймээс АИХ-аас хууль тогтоогч УБХ-д суудал хуваарилахад сөрөг хүчний намууд нийт 19 суудалтай (МАХН 31 суудал авсан) болж чадсан нь том амжилт боллоо. Үүнийхээ хүчээр сөрөг хүчний намууд Монгол орныг зах зээлийн харилцаанд оруулах үйл явцыг зохицуулах хууль боловсруулах ба батлахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг олж авсан билээ.

Монгол Улсын түүхэнд анх удаа ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгов. АИХ-ын гишүүдийн 88,15% нь тэр үеийн УИХ-ын тэргүүлэгч П. Очирбатыг (МАХН) Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонголоо. Социал Демократ намын гишүүн Р. Гончигдорж давтан сонгуулиар 66,1%-ийн санал авч сөрөг хүчний хамтран зүтгэгч С. Зоригийг (С. Зориг нийт саналын 33,17 %-ийг авсан) ялж гарч ирсэн нь бэлэг тэмдгийн шинж чанарыг агуулсан үзэгдэл байлаа. АИХ-ын орлогч даргын албан тушаал, мөн ерөнхий сайдын орлогчийн албан тушаалыг сөрөг хүчнийхэн эзэлж чадсан нь гайхамшигтай бөгөөд итгэл үнэмшил төрүүлэхээр явдал боллоо. АИХ-ын гишүүд Ж. Гомбожавыг (МАХН) АИХ-ын даргаар, Л. Дашням (МҮДН), Ц. Адьяасүрэн (МСДН) нарыг түүний орлогчоор тус тус сонгов. Да. Ганболд (МҮДН), Д. Дорлигжав (МоАН) нар ерөнхий сайд Д. Бямбасүрэнгийн толгойлсон анхны ардчилсан засгийн газрын ерөнхий сайдын орлогчоор томилогдсон байна. Сөрөг хүчин анх үүссэн цагаасаа хойш есөн сарын дотор төрийн дээд албан тушаалд орж ажиллаж чадсан нь тэдний хувьд маш том ялалт хэмээн тооцогдож байлаа. Гэтэл энэ зоос хоёр нүүртэй байсан ажээ. МАХН-ын удирдагчид бага ч гэсэн хугацаанд амсхийх боломжтой болжээ. Тэдний хувьд Ардчилсан Социализмын Хөдөлгөөний гүйцэтгэх зөвлөлийн тэргүүн Р. Гончигдорж, МҮДН-ын удирдах зөвлөлийн тэргүүн Да. Ганболд, МҮДН-ын сонины ерөнхий эрхлэгч Л. Дашням, МСДН-ын улс төрийн зөвлөлийн гишүүн Ц. Адьяасүрэн, МоАН-ын дэд дарга Д. Дорлигжав зэрэг сөрөг хүчний хамгийн чухал идэвхтнүүдийг төрийн чухал албан тушаалуудад нэгтгэн оруулж чадлаа.

Сөрөг хүчнийхэн МАХН-ын хувьд гудамжинд эсэргүүцлээ өрнүүлэн дарамт үзүүлж байхдаа л хамгийн хяналтгүй аюултайд тооцогдож байсан аж. Гэтэл одоо захиргааны учир нь ойлгогдох дүрэм журамд ардчилал захирагдах болж, захиргааны асуудлууд ба улс төрийн бодлогоо түүнд тааруулан тохируулах туршлага сөрөг хүчнийхний өмнө тулгарав. Энэ талаар МАХН-ын боловсон хүчид мэргэжлийн уламжлалтай учраас хэрхэн хөдлөхөө тэд сайтар мэдэж байлаа. Ингээд сөрөг хүчин эрх чөлөөт гудамжнаасаа хөндийрч орхив. Одоо МАХН сөрөг хүчнийхэнтэй захиргааны асуудлаар тайван байдалд мэтгэлцэх бололцоотой болжээ. Гаднаас нь өнгөц харахад МАХН шилжилтийн энэ үед харилцан зөвшилцөхөд бэлэн байгаа мэт дүр эсгэж чадав. Хамгийн чухал зүйл бол монголчууд ардчилал руу тайван замаар орсон явдал байлаа.

Хамгийн анхны чөлөөт сонгууль нь монголчуудад олон жилийн турш ЗХУ-д дарлагдаж байсан тэр үеийн боогдмол сэтгэгдэл, санаа бодлыг нь хязгааргүй эрх чөлөөтэй болгож өгсөн мэт өнгөц сэтгэгдэл төрүүлсэн билээ. 1990 оны зун монголчууд урд өмнө нь хэзээ ч байгаагүй тийм үндэсний хэмжээний мансуурлын байдалд орсон юм. Орон даяараа монголын эзэнт гүрний цор ганц түүхэн бичиг "Монголын нууц товчоо"-ны 750 жилийн ойг өргөн тэмдэглэж өнгөрүүлэв. Жинхэнэ хэрэг дээрээ монголчууд Москвагийн зүгээс 1962 онд хамгийн зэрлэг феодал хэмээн хараан зүхсэн¹, монголчуудын эцэг, эзэн Чингис хааныхаа баярыг тэмдэглэсэн нь тэр бөлгөө. МАХН-ын зүтгэлтнүүд ард түмний дунд цэцэглэн байгаа энэхүү уур амьсгалыг хуваалцсан болж үүнийг далимдуулан өөрсдийн улс төрд байр сууриа эзлэх боломжоо ч тооцоолж байсан билээ. МАХН-ын удирдагчид чухал тохиолдлууд дээр үг хэлэхдээ үндсэний хувцсаа өмсөн, монголчуудын түүхэн өнгөрсөн үе ба ирээдүйн тухай сэдвүүд хөндөн ярих боллоо. Ерөнхийлөгч П. Очирбат Монгол орон тун удахгүй "Азийн бар" орон болно хэмээн тунхаглав. МАХН өөрийн намын хөтөлбөрийг маш яаралтай өөрчиллөө. 1990 оны 4-р сараас 1991 оны 2-р сарын хооронд намын хөтөлбөрийг хоёр ч удаа шинэчлэн батлав. 1990 оны 4-р сард "монголын хүмүүнлэг, ардчилсан, социалист нийгэм" байгуулах тухай ярьж байсан бол 1991 оны 2-р сард "социалист үзэл санааг баримталсан ардын ардчилсан нам" хэмээн ярьж эхлэсэн байна.

Үндэсний уламжлалыг сэргээх асуудал МАХН-ын дотор ч яригдах болов. МАХН-ын XX Их Хурлын (1991 оны 02-р сарын 25.-28.) төлөөлөгчид философч Б. Даш-Ёндонг намынхаа ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон байна. Даш-Ёндон эртний философийн сургааль дээр суурилсан "төв үзэл" гэгчийг намынхаа үзэл баримтлал болгон тунхагласан байна. Монголчууд түүний энэ санааг бараг л ойлгож хүлээн аваагүй боловч тухайн цаг үед үндэсний ухамсар, уламжлалт зан заншлын тухай бичдэггүй өдөр тутмын сонин хэвлэл гэж огт байгаагүй юм. Хамгийн том нам нийгмийн маргаантай асуудлууд дотор хөвсөөр, ингээд ч энэхүү нам нь марксизм-ленинизмийн тухай дурсахаа ч байсан нь олны нүдэнд өртөөгүй бололтой. МАХН-ын XXI Их Хурлын төлөөлөгчид (1992 оны 02-р сарын 26.-28.) түрүүчийн хурлаас жилийн дараа шинээр намын хөтөлбөр баталсан нь энэ намын түүхэнд долоо дахь мөрийн хөтөлбөр нь болжээ.² МАХН нь өөрийгөө "үндэсний эв нэгдэл, нийгмийн хөгжил дэвшлийг гүйцэтгэгч" "ардын ардчилсан нам" хэмээн тодорхойлсон байна. Марксизм-Ленинизм буюу социализмын тухай огт дурссангүй. Энэ нам маш хээнцэр маягаар өөрийн хуучин үзэл суртлаасаа мултарч чадлаа.

Шинэ үндсэн хуулийг баталсан нь

Улс төрийн намууд дараагийн шатандаа шинэ Үндсэн Хуулийг боловсруулан батлах ажил руу шамдан оров. Энэхүү шинэ Үндсэн Хууль монголын цаашдын хөгжилд хичнээн өндөр ач холбогдолтой болохыг бүгд хүлээн зөвшөөрч байлаа. УБХ-аас ерөнхийлөгч П. Очирбатаар удирдуулсан үндсэн хуулийн төсөл гаргах ажлын комиссыг томиллоо. 16 гишүүнтэй энэхүү комиссын бүрэлдэхүүнд МАХН-ын төлөөллөөс гадна МҮДН, МоАН, МНН болон МЧХН-ын төлөөлөл багтан оров. 1991 оны 4-р сарын 10-ны өдөр бэлэн болсон Үндсэн Хуулийн төслийг УБХ-аар хэлэлцэн 6-р сарын 05-ны өдөр хэвлэгдэн гарлаа. УБХ олон нийтийг тус Үндсэн Хуулийн төслийг авч хэлэлцээд энэ талаар санаа бодлоо илэрхийлэхийг уриалсан байна. Тусгай ажлын бүлэг иргэдээс ирсэн саналуудыг шүүн хэлэлцэж байлаа. Энэхүү анхны төслийг хэд

¹ U. B. Barkmann, Das Tschingis-Chaan-Jubiläum im Jahre 1962, *Mongolische Notizen, Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft* 3(1999), 33-37-р тал.

² U. B. Barkmann, Zum politischen Selbstverständnis der Mongolischen Revolutionären Volkspartei, *Asien, Afrika, Lateinamerika*, vol. 24(1996), 475-496.

хэдэн удаа ахин боловсруулсан билээ. 1992 оны 01-р сарын 13-ны өдөр АИХ-аас тус Үндсэн Хуулийг батлав. Ингээд 1992 оны 02-р сарын 12-ны өдрийн 12 цагаас шинэ Үндсэн Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэллээ.¹

Монгол Улс шинэ үндсэн хуулиндаа “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” (оршил) “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах” (1-р бүлэг, 1-р зүйл) гэдгээ албан ёсоор хүлээн зөвшөөрлөө. Үндсэн Хуулинд: “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” (1-р бүлэг, 3-р зүйлийн 1)² АИХ шинэ Үндсэн Хуулийг хүлээн авснаар засаглалын эрх мэдлийн хуваарилалт (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал), эрх зүйт төр болон ардчиллыг Үндсэн Хуулийн баримтлах зарчмын цөм болохыг баталгаажуулсан билээ. Төрийн зүгээс “нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэр”-үүдийг хүлээн зөвшөөрсөн ба аливаа өмчийн эрхийг хуулийн хамгаалалтанд авав. Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт “Хүний эрх, эрх чөлөө”-ний асуудалд сонгох ба сонгогдох эрх (насанд хүрсэн 18 буюу 25 наснаас эхлэн), мөн “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” хэмээх эрхүүдийг заан оруулж өгчээ.

“Төрийн эрх барих дээд байгууллага” нь хууль тогтоох эрх бүхий УИХ (өмнө нь АИХ гэдэг байсан) байх ба парламент нь “нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох”-оор дөрвөн жилийн хугацаатай сонгогдсон, 76 гишүүнтэй, нэг танхимтай байхаар заажээ.

Үндсэн Хуулинд ерөнхийлөгчийг “төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч” хэмээх заалтыг оруулсан байна. Үндсэн Хуулийн дагуу парламентад суудалтай намууд ерөнхийлөгчийн суудалд нэр дэвшүүлэх эрхтэй. “Нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох”-оор хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ерөнхийлөгчээр дөрвөн жилийн хугацаатайгаар сонгоно.

Шинэ Үндсэн Хууль нь Монгол оронд урд өмнө хэзээ ч байгаагүй ардчилсан журмаар хэлэлцэгдэж байж батлагдсан билээ. Үндсэн Хуулийг боловсруулахад хамтран ажилласан байдлаас дүгнэлт хийвэл монголын улс төрийн намууд энэ хугацаанд хамтран ажиллаж чадаж байгаагаар зогсохгүй хамтраад тодорхой үр дүнд хүрч чадах юм гэдэг нь тодорхой болсон билээ. Монголын ардчилал хэдий нягх балчир байсан хэдий ч энэ бол чамлахааргүй амжилт байв.

1991 оны эхээр Ерөнхийлөгч П. Очирбат “Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай БНМАУ-ын хууль”-ийг батлав. Энэхүү хууль нь юуны түрүүнд ерөнхийлөгчийн, дэд ерөнхийлөгчийн, УБХ-ын даргын албан тушаалууд, бүх шатны шүүхийн дарга нар, дэд дарга нар, гишүүд ба шүүгчид, Монгол улсын бүх шатны прокурор ба мөрдөн байцаагч нар, цэрэг армийн албан хаагчид, цагдаа, аюулаас хамгаалах албаныхан, засан хүмүүжүүлэх албаныхан, гадаад харилцааны ажилтнууд, төрийн хэвлэл мэдээллийн удирдах ажилтнууд ба ажиллагсдад хамааралтай байх ёстой.³ Энэхүү хууль туйлын ач холбогдолтой болов. Дээд тушаалын албан хаагчид аль нэг намын харьяалалд үйлчлэхгүй болсон бөгөөд тэд албан үүргээ хэнээс ч хамаарахгүй гүйцэтгэх боломжтой боллоо. Энэ хууль хэр амьдралтай байж чадсан эсэх нь П. Очирбат ерөнхийлөгчийн хувь хүний өөрчлөлт дэвшлээс ихээхэн хамаарсан байдаг.

¹ Монгол Улсын Үндсэн Хууль, Улаанбаатар 1992, 30-р тал.

² Мөн тэнд, 3-4-р тал.

³ Ардын Эрх, 1991 оны 9-р сарын 5.

1992 оны парламентийн сонгууль

1992 оны 04-р сарын 4-ний өдрийн хуралдаанаар УБХ-аас "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай" шинэ хууль батлан гаргав.¹ Энэхүү хууль нь өнгөрсөн хугацаанд Үндсэн Хуулинд заалт болон орж баталгаажуулсан иргэдийн "нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох" эрхийн хүрээнд парламентийн сонгуулийг явуулах асуудлыг баталгаажуулж өгсөн билээ. Тус хууль сонгуулийн ил тод байдал болон сонгууль явуулах аж ахуй, эрх зүйн баталгааг тогтоосон юм. Хууль тогтоогчдын зааснаар улс төрийн намууд бие дааж, эвсэл бусад намуудтай хамтран эвсэл болж сонгуульд оролцох эрхтэй ажээ. Монгол улсын иргэн бие даан нэрээ дэвшүүлэх тохиолдолд өөрийн нэр дэвших тойргоосоо түүнийг дэмжсэн 801 сонгогчийн гарын үсэг цуглуулсан байх ёстой юм. Сонгуулийг сонгуулийн тойрог ба сонгуулийн хэсэг гэсэн зохион байгуулалттай явагдах ажээ. Сонгуулийн нэг хэсэгт дүрэм ёсоор 1.500 сонгогч бүртгэгдсэн байх ёстой. Харин Улаанбаатар хотын хувьд байдал арай өөр байх ёстой бөгөөд сонгуулийн нэг хэсэгт 6.000 сонгогч оршин суудаг байна. Үндсэн Хуулинд парламентийн суудлыг 76 хэмээн тогтоосон учраас улс орон даяар 76-аас илүү тооны сонгуулийн тойрог байх ёсгүй. УИХ-ын Сонгуулийн Ерөнхий хороо, мөн сонгуулийн тойрог ба хэсгүүд дэх сонгуулийн хороод нь сонгуулийг зөрчилгүй явуулах ажлыг хянах үүрэгтэй. Хуулинд зааснаар сонгуульд өрсөлдөх намууд, намын эвслүүд болон бие даан нэр дэвшигч нар "сонгууль өгөхөөс хорин дөрвөн цагийн өмнө" багтаж сонгуулийн өмнөх сурталчилгааг явуулж дуусгасан байх дүрэмтэй ажээ. Бүх нэр дэвшигчдэд радио, телевизээр сонгуулийн сурталчилгаагаа тодорхой хугацаа аван үнэ хөлсгүй нэвтрүүлэх боломж олгосон ба төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэт нэг талыг барьсан сурталчилгаа хийхийг хориглов. Мөн саналын хуудсыг тоолох ажлыг нээлттэй, өөрөөр хэлбэл ажиглагчид, сонгогчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөллийг оролцуулан хийхээр хуулийн заалтыг баталсан билээ. Хамгийн олон санал авсан нэр дэвшигч парламентийн суудлын тоог харгалзан УИХ-д суудалтай болох ёстой. Сонгуулийн бүхий л үйл явцыг гадаадын сонгуулийн ажиглагч нарын хяналтын дор явагдах болов. Хуулинд зааснаар: "Гадаадын ажиглагч оролцуулах асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо төрийн гадаад харилцаа эрхэлсэн байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэнэ. (7-р бүлэг, 34-р зүйл, 2)"²

УИХ-аас 1992 оны 06-р сарын 28-ны өдөр парламентийн сонгуулийг явуулахаар товлон. Парламентаас орон даяар хичнээн сонгогчтойгоос хамаараад сонгуулийн 76 тойрогт суудлын тоог хуваарилсан байна (тус бүр 2 суудалтай 8 тойрог, тус бүр 3 суудалтай нийт 12 тойрог, тус бүр 4 суудалтай нийт 6 тойрог). Аймгууд, мөн Дархан, Эрдэнэт нь тус тусдаа сонгуулийн тойргууд боллоо. Харин Улаанбаатар хотыг нийтдээ 6 тойрогт хуваав. Тэр үед Дээд Шүүхэд бүртгэлтэй байсан улс төрийн 12 нам өөр өөрийн нэр дэвшигчээ сонгуульд өрсөлдүүлэхээр шийджээ. Харин зарим сөрөг хүчний намууд 1990 оны сонгуулийн туршлагаасаа дүгнэлт хийн сонгуулийн эвсэл байгуулахаар шийдсэн билээ. МоАН, МНН ба МҮДН гурав нийлж сонгуулийн эвсэл болох "МоАН, МНН, МҮДН-ын Эвсэл"-ийг байгуулав. Мөн Монголын Сүсэгтний Ардчилсан Нам, Монгол Ардын Нам хоёр сонгуулийн эвсэл байгуулсан байна. МАХН парламентийн бүх 76 суудалд өөрийн хамгийн тэргүүн гэсэн хүнийхээ нэрийг дэвшүүлж чадсан байхад "МоАН, МНН, МҮДН-ын Эвсэл" нийтдээ 48, МСДН ганцаараа 28 хүний нэрийг дэвшүүлэв. Сөрөг хүчний бусад намууд нийлээд 141 нэр дэвшигчийг өрсөлдүүлсэн байна.

Сонгуулийн дүн сөрөг хүчнийхний хувьд тун ч гутармаар байдалд оруулжээ. МАХН УИХ-д нийтдээ 70 суудалтай боллоо. Гэтэл "МоАН, МНН,

¹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Хууль, Улаанбаатар 1992.

² Мөн тэнд, 16-р тал.

МҮДН-ын Эвсэл" ердөө л 4 суудал, МСДН 1 суудал (+ бие даасан нэр дэвшигчийн 1 суудал) тус тус авч чадав. Сөрөг хүчнийхэн яагаад ялагдал хүлээв? Хэрэв тэд намуудын томоохон эвсэл байгуулсан бол арай өөр үр дүн гарах байсан болов уу. Учир нь олон тооны нэр дэвшигчтэй байх нь хэргийн гол нь бус, харин тэдгээр нэр дэвшигчдээс чанартай сонголт хийх боломжтой байх байсан болов уу. Сөрөг хүчний нэр дэвшигчдийн дийлэнх нь сонгуулийн өрсөлдөөний үеэр улс төрийн талаар туршлагагүй бөгөөд тодорхой үзэл баримтлал гэхээр зүйлгүй байсан. Үнэн хэрэгтээ нэр дэвшигчдийн ярьж хэлж байгаа байдал, олон түмэнд танил байх, намынх нь дэмжлэг, сонгуулийн өрсөлдөөнд гаргасан хөрөнгө хүчний бололцоо, намын мөрийн хөтөлбөр амьдралд хэр ойр бууж байсан зэрэг хүчин зүйлүүдээс сонгогчдын шийдвэр хамаарч байсан билээ. Эдгээр олон үзүүлэлтийн хувьд сөрөг хүчний намууд тун ч бэлтгэлгүй байхад МАХН тогтвортой байдалдаа эргэн орж чадсан юм. Мөн нэр дэвшигчид нь тухайн нутгийн уугуул иргэд байсан, иймээс ч тухайн сонгуулийн тойргийнхоо тулгамдсан асуудлуудын талаар нэлээд мэдлэгтэй байсан нь ч чамлахааргүй ач холбогдолтой байжээ. Нийслэл хотоос алслагдсан Баян-Өлгий зэрэг аймгийн иргэд парламентад өөрсдийн сайн төлөөлөлтэй болгохын тулд Улаанбаатар хотод өөрийн намын зүгээс хүчирхэг лобби бүхий тийм нэр дэвшигчийг л сонгох хэрэгтэй билээ. Ийм аймгийн ийм сонирхол бүхий сонгогч хуулийн дагуу батлагдсан ердөө л 801-ээс илүүгүй гишүүнтэй хаа хамаагүй нэг намын нэр дэвшигчийг сонгох гэж үү? Үнэн хэрэг дээрээ монголын баруун аймгууд болох Баян-Өлгий, Ховд, Увсын сонгогчдын ердөө л 5,9 %, 9,9 %, 9,8 % нь л "Ардчилсан Эвсэл" холбооны төлөө саналаа өгсөн юм. Харин тус эвслийн төлөө санал хамгийн өндөр санал өгсөн аймгууд нь Баянхонгор, Хөвсгөл, Дорнод, Дундговь, мөн Дархан, Улаанбаатар, Эрдэнэт хотууд болов. Аймгуудад дундажаар 23,2 % ба хотуудад 22,03 %-ийн санал авчээ. 1992 оны 07-р сарын 20-ны өдөр ерөнхийлэгч П. Очирбат УИХ-ын чуулганыг нээж үг хэлэв. Сонгуулийн ерөнхий хорооны (дарга нь С. Лхагвасүрэн) тайланг авч хэлэлцсэний дараа сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч, Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөцгөөлөө.

"МоАН, МНН, МҮДН-ын Эвсэл" холбооныхон сонгуулийн барианд дүгнэлт хийж олон намуудыг нэгтгэх шийдвэр гаргав. МоАН, МҮДН, Монголын Сэргэн Мандлын Нам, МНН-ууд хамтарсан хурлаараа (1992 оны 10-р сарын 25.-26.) Монголын Үндэсний Ардчилсан Нам (МҮАН) болон нэгдлээ. Д. Ганболдыг тус намын тэргүүнээр сонгов. МҮАН-ын гишүүдийн тоо намын өөрийнх нь тооцоогоор нийтдээ 41.500 хүрсэн байлаа. Намууд Дээд Шүүхэд бүртгүүлж байсан үетэй нь харьцуулбал энэ тоо нэлээд дээгүүр санагдаж байна. Сонгуульд ялагдал хүлээсэн явдал нь намуудын тогтвортой байдалд нилээд нөлөөлсөн байна. МҮАН тэр үед энэ намын гишүүн төдийгүй дэмжигчдийг ч мөн гишүүдийн тоонд багтаан оруулж тооцоолсон байх талтай. Энэ байдал өнөөдөр ч мөн ажиглагдаж байгаа юм. "Улс төрийн намуудын тухай" хуулинд "намын гишүүн" гэсэн нэр томъёог сайн тодорхойлоогүй байгаа нь энэхүү байдалд хүргэсэн байх боломжтой.

1993 оны Ерөнхийлөгчийн сонгууль

Сөрөг хүчний намуудын цөм нь болсон ялангуяа МҮАН, МСДН-ынхан анхаарлаа 1993 онд болох ерөнхийлөгчийн сонгуульд хандуулав. Ерөнхийлөгч П. Очирбат МАХН-ын гишүүн байсан ба УИХ дахь МАХН-ын бүлгээс ерөнхийлөгчид нэрийг нь дэвшүүлэн сонгогдсон билээ. Тэрээр дээр дурьдсан "Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай" хуулинд заасан ёсоор ерөнхийлөгчийн албыг хүлээж аваад намын харьяаллаасаа татгалзан улс төрийн хувьд бие даасан хувь хүн болсноор хуучин харьяалагдаж байсан намынхаа шахалт дарамтаас чөлөөлөгдсөн байна. Ерөнхийлөгчийн албан тушаал хашиж байгаа иргэн нь улс төрийн хувьд төвийг сахисан "төрийн

тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч" учраас ерөнхийлөгчийн улс төрийн гүйцэтгэх үүрэг илүүтэй гүнзгийрч ирэв. Түүний бүрэн эрх, албан үүргийн тухай заалтуудыг шинэ Үндсэн Хуулинд, мөн 1993 оны 06-р сарын 05-ны өдөр батлагдсан "Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай" хуулиар илүү тодорхой зааж өгсөн байна. Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, гадаад харицлааны салбарт мөн тодорхой албан үүрэг гүйцэтгэхээс гадна ерөнхийлөгч нь хууль санаачлах, парламентаас гаргах хуулийн төсөлд санал оруулах, парламентаас гаргасан хуулинд хориг тавих зэрэг түүний өөрийн сонирхолд нийцэх практик үйлдлүүдийг ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх боломжтой ажээ. Үндсэн хуулинд зааснаар:

"1. Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1) Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;
- 2) Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;"¹

1993 оны 2-р сард МҮАН, МСДН-ын удирдлагууд тус хоёр намын улс төрийн үйл ажиллагааг илүүтэйгээр зангидаж явуулахаар тохиролцов. Тэд ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хамтран ажиллах баримт бичигт гарын үсэг зурлаа. Хэд хэдэн удаа дахин сонгууль явуулсны дүнд МҮАН, МСДН ерөнхийлөгч П. Очирбатыг өөрсдийн намаас хамтран нэрийг нь дэвшүүлэх шийдвэр гаргав. П. Очирбат эдгээр хоёр намын эвслээс ирсэн нэр дэвшүүлэх тухай саналыг зөвшөөрсөн тухай хариугаа бичгээр илгээв. П. Очирбат өөр намаас нэр дэвших болсон нь МАХН-ын хувьд том ялагдал болов. Ингээд Л. Түдэвийг намынхаа нэрийн өмнөөс нэрийг нь дэвшүүллээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн 1993 оны 2-р сарын 15-ны өдөр УИХ "Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн хууль"-ийг батлан гаргав.²

1993 оны 6-р сарын 6-ны өдрийн сонгуулиар хуучин ерөнхийлөгч П. Очирбат илэрхий давуу ялалт байгуулав. Сонгогчдын 57,8 % нь түүний төлөө саналаа өгсөн байхад зөвхөн 38,7 % нь Л. Түдэвт саналаа өгчээ. Ямар шалтгаанаар дийлэнх сонгогчид хуучин Ерөнхийлөгчийн төлөө саналаа өгөв? МҮАН-ын улс төр судлалын институт энэ талаар судалгаа хийжээ. Асуулганд хамрагдагсдын 48,1 % нь ерөнхийлөгчийг солих шаардлагагүй буюу одоогийн Ерөнхийлөгчийн албан үүргээ гүйцэтгэж байгаа байдалд сэтгэл хангалуун байгаа ажээ. 45,7 % нь П. Очирбатын хувь хүнийх нь зан чанар таалагддаг гэнэ. Нэр дэвшигчийн төлөө өгсөн саналд намын харьяалал нөлөөлсөнгүй. Санал асуулгын дүнгээс ажиглахад МАХН, МҮАН-ын гишүүдийн аль аль нь П. Очирбатын нэр дэвшсэн явдалд сэтгэл хангалуун байсан байна. Иймээс түүний ялалтыг зөвхөн сөрөг хүчний ялалт хэмээн ойлгож болохгүй нь. Ингээд сөрөг хүчин тодорхой нөхцөл байдал нь тэдний хувьд ашигтайгаар эргэх боломжтой юм гэсэн өөдрөг сэтгэгдэлтэй үлдсэн байна. Очирбат өөрийн төрсөн Завхан аймагтаа 78,72 %-ийн санал авсан нь хамгийн өндөр амжилт бөгөөд гайхаад байхаар зүйл огт биш юм. Монголын улс төрчдийн хувьд "төрсөн нутгаасаа" гэсэн ойлголт түгээмэл ажиглагддаг бөгөөд тэд нутгийнхнаасаа маш хүчтэй дэмжлэг авч чаддаг байна. Очирбат сонгуулийг хүлээн зөвшөөрлөө. Тэр өөрийн сонгуулийн штабыг удирдаж байсан М. Энхсайханыг (МҮАН) Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын албан тушаалд томиллоо. Сонгуулийн дүнг ажиглахад

¹ Монгол Улсын Үндсэн Хууль, Улаанбаатар 1992, 17-р тал.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Хууль, Улаанбаатар 1997.

монголын иргэд өнгөрсөн хугацаанд ардчилсан системийг сэтгэлээрээ хүлээн авсан нь тун тодорхой болжээ. Сонгуулийн дүнд нэгэн шинэ нөхцөл байдлыг бий боллоо: МАХН-ын засгийн газар, УИХ дахь МАХН-ын бүлэг “өөрсдийнх нь нэг нь” байсан, одоо тэрхүү “хуучин нөхөдтэйгээ” тодорхой зайнаас харьцах болсон бүх монголчуудын ерөнхийлөгчтэй ажиллах шаардлага үүссэн юм.

Дотоод улс төрийн нөхцөл байдал

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр эдийн засгийн гүн хямралд орж, хямралын оргил үе нь 1990-ээс 1995 онуудыг хамарч байв. Хямрал олон тодорхой хүчин зүйлүүдээс шалтгаалан үүссэн ба тэдгээрийг энд тоочихыг хүссэнгүй.

Монголын Засгийн газар хувьчлалын бодлогыг тууштай хэрэгжүүлэв. Хувьчлалын эхний ээлжинд малыг малчдад нь хувийн өмч болгон өгөв. Гэхдээ малыг малчдад нь хувьчлах энэ шийдвэр маргаангүйгээр гарсангүй, сөрөг хүчний хүчтэй шахалтын дүнд л гарч чадсан байна. 1957/1958 оны нэгдэлжих хөдөлгөөний хүрээнд малыг малчдын хүсэл сонирхлынх нь эсрэг хураан авч “нийгмийн” өмч болгож байсан түүхийг эргэн санавал уг хувьчлал түүхэн алдааг тодорхой хэмжээнд эргүүлэн зассан алхам болов. Малын хувьчлал нь орон нутаг дахь нийгмийн болон хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд өөрчлөлт оруулсан үр дагаврыг авч ирэв. Социализмын үед улам хүрээгээ тэлж байсан захиргааны нүсэр бүтэц, үүнтэй уялдсан аж ахуйн хэлбэр нуран унаж, суурин хүн амын ихээхэн хэсэг нь мал аж ахуйн салбар руу шилжсэн байна. Ингэснээр 1990 онтой харьцуулахад 1993 онд малчдын тоо хоёр дахин өсч, нийтдээ 347.900-д хүрч байжээ. Энэ үүднээс зарим судалгаанууд хөдөөгийн хүн ард нүүдлийн аж амьдрал руу эргэн орж байна гэж үзэж байгаа юм.¹

Үйлдвэрлэлийн салбарт мөн гүн гүнзгий өөрчлөлт гарав. Улсын олон үйлдвэр хаагдав. Улсын үйлдвэрүүд төрөөс дэмжлэг авахгүй болсноор шаардлагатай түүхий эдээ авах, машин техникээ засварлаж чадахгүйд хүрч, экспортын чиглэлийн үйлдвэрүүд зүүний блох нуран унаснаар уламжлалт худалдан авагчдаа бүрэн алдсан байна. Бараа болон хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт эрс багасав. Улаанбаатар хотын засаг захиргаа хүнсний бүтээгдэхүүнийг картын системд оруулсан юм. 1993 оны эхээр нийслэлийн нэг иргэнд 2,3 кг 1-р гурил, 1,7 кг 2-р гурил, 2 кг мах оногдож байв. Гэвч засгийн газар эцэстээ хүнсний бүтээгдэхүүний үнийг чөлөөлсөн юм.

Хямрал даамжирсаар нийгмийн бүхий л хүрээг хамрах болов. Ийм нөхцөлд нийгмийн дэг журам нуран унах аюул нүүрлэж байв. 1992 онд Улсын Их Хурал хүнд нөхцөл байдлын улмаас “Нийгмийн дэг журмыг сахин хангахад төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл” гэсэн тогтоолыг гаргасан байна.² Гэвч энэ тогтоол нийгмийн зэврэлийн үргэлжлэлийг зогсоож чадсангүй.

1991-1995 онуудад хүн амын ихээхэн хэсэг ядуурав. Амьжиргааны доод түвшнээс доогуур амьдралтай иргэдийн хувь 1991 онд 14,5 % (=320.513 хүн) байсан бол 1995 он гэхэд 36,3 % (=828.000 хүн) болж өсчээ. Энэ тоо 1995 онд хөдөөд 33,1 % (=471.000 хүн), хотуудад 38,5 % (=350.000 хүн) байв. 1993, 1994 онуудад ядуурал хөдөөд хотоос илүү байсан бол 1995 онд энэ харьцаа солигдсон байна.³ Хүн амын ийм ядуурал нь юуны эмэгтэйчүүд, залуучууд ажил мэргэжлийн хувьд өөрөөр хандах шаардлагыг үүсгэсэн байна. Тэд Орос, Хятад руу явж жижиг худалдаа эрхлэн бараагаа Монголд борлуулах болжээ. Жижиг худалдаа эрхлэлт улам ихэсч, дараагийн жилүүдэд дотоод худалдаа дахин сэргэхэд ихээхэн нэмэрлэв. Аж үйлдвэрийн салбарын найдваргүй байдал нь мэргэжлийн ажилчид олноороо ажилгүйчүүдийн эгнээнд ороход түлхэц болов.

¹ В. В. Грайворонский, Современное аратство Монголии, социальные проблемы переходного периода 1980-1995, Москва 1997.

² Ардын Эрх, 1992 оны 10-р сарын 31.

³ Х. Гүндсамбуу, Монголын нийгмийн давхраажил: Хөгжил, Хандлага Улаанбаатар 2002, 481-р тал.

1993 оны 1-р сарын 1 гэхэд мэргэжлийн ажилчид бүртгэлтэй ажилгүйчүүдийн 23,1 %-ийг эзэлж байв.¹ Боловсруулах үйлдвэрийн мэргэжлийн маш олон ажилчид өөрийн салбарын хурц хямралын улмаас салбараа орхин, жижиг үйлдвэрлэл, жижиг худалдаа руу дайжсан байна. Боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 1990 онд 123.400 байснаа 1995 онд 67.300 болон буурчээ.

Зарим хэсэг нь гадаадад гарч хөдөлмөр эрхлэх болов. Зөвхөн 1993 онд гэхэд казак ястан 39.190 иргэн нутгаа орхин, хөрш Казакстанд азаа сорихоор оджээ.²

Өсөн нэмэгдсэн ядуурал нь архидалт, гэмт хэргийн тоо өсөх үр дагаврыг авч ирэв. 1992 оны эхний 11 сарын байдлаар гэмт хэргийн тоо 25,4 %-оор өссөн байх юм.

Хөгжлийн ийм сөрөг дүр төрх засгийн эрхэнд байсан МАХН-д нөлөөлсөн юм. МАХН-ын олны танил улс төрчид болох Д. Бямбасүрэн, Ц. Цолмон, Н. Уртнасан, Ж. Амарсанаа нар МАХН-аас гарав. Тэд Монголын Сэргэн Мандлын Намыг байгууллаа. Хэдийгээр нийгмийн байдал улам хурцадсан боловч улс төрийн намуудын төлөв байдал энэ шинэ намыг эс тооцвоос тогтвортой байв. 1997 оныг дуустал шинэ нам сүрхий нэмэгдэж байгуулагдсангүй.

1994 оноос эдийн засгийн өсөлт тогтворжих хандлагатай болов. Дотоодын нийт бүтээгдэхүүн 1994 2,3 %-аар, дараа жил нь бүр 6,5 %-аар өслөө. Гэвч эдийн засгийн энэ өсөлт харьцангуй зүйл байсан ба өсөлтийн тоо хэмжээ бодит байдалтай нийцсэнгүй. Ямарч болов эдийн засгийн өсөлт цаашаа унаж чадахааргүй хамгийн доод төвшинөөс эхэлсэн юм. Япон улсын санаачлагаар бий болсон хандивлагч орнуудын бага хурлаас донор орнууд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах зорилгоор Монголд өргөн хүрээтэй тусламж, зээлийг олгож эхэлсэн билээ. Сөрөг хүчний намуудын гол цөм нь болсон МҮАН, МСДН намуудын хооронд энэ хугацаанд харилцан ойртох үйл явц өрнөж эхлэв.

1996 оны парламентийн сонгууль

МҮАН, МСДН намууд 1996 оны парламентийн сонгуульд хичээнгүйлэн бэлтгэв. Тэд „Ардчилсан Холбоо“ сонгуулийн эвслийг байгуулахаар тохиролцон, сонгуулийн бэлтгэл ажлаа олон нийт рүү түлхүү чиглэсэн арга хэмжээгээр явуулав. Ийм арга хэмжээний нэг нь МҮАН-ын шинэ даргыг сонгох сонгууль байв. 1995 оны 12-р сарын 1-нээс 25-ны хооронд тус намын хамгийн дээд албан тушаалд таван хүн өрсөлдөхөөр бүртгүүлсэн юм. 1996 оны 1-р сарын 6-нд хуралдсан МҮАН-ын 5-р чуулганаас Ц. Элбэгдорж, Да. Ганболд нар намын даргад өрсөлдөх болжээ. МҮАН-ын удирдлага 1996 оны 1-р сарын 8-аас 2-р сарын 8-ны хооронд сонгуулийг орон нутгуудад зохион байгуулахыг аймгуудын намын хороодод даалгав. Энэ сонгуулиар Ц. Элбэгдорж саналын 59,6 %, Да. Ганболд 40,5 %-ийг авчээ. МҮАН-ын II Их Хурлаар (1996 оны 04-р сарын 04.-05.) Ц. Элбэгдоржийг МҮАН-ын даргаар сонгогдсоныг батлав. Мөн тус намын Их Хурлаар „Ардчилсан Холбоо эвслийн сонгогчидтой байгуулах гэрээ“-г хэлэлцэн сонгуулийн мөрийн хөтөлбөр болгон баталсан юм. Эвслийн ерөнхий нарийн бичгийн дарга, тухайн үед Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар ажиллаж байсан М. Энхсайханыг „Ардчилсан Холбоо“-ны сонгуулийн төв штабын даргаар томилов. Энхсайхан нэр дэвшигчдийг тодруулах ажлыг түргэвчиллээ. 1996 оны 04-р сарын 13-нд эвслээс нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг „Сайн байна уу“ сонинд нийтэлсэн ба нэр дэвшигчдийн 50 нь МҮАН-аас, 26 нь МСДН-аас байв. Намууд уг сониныг 500 мянган ширхэг хэвлэн сонгуулийн тойргуудад тараасан байна.

¹ Ардын Эрх, 1993 оны 2-р сарын 2.

² Мөн тэнд.

МАХН сонгуулийн өмнөх кампанит ажилд маш алгуурхан орсон юм. Тус намын удирдлага эдийн засгийн тогтворжуулсан бодлогыг нь сонгогчид дэмжин үнэлэх байх гэдэгт бүрэн итгэлтэй байв. МАХН-ын илт давуу төлөөлөлтэй Улсын Их Хурал 1992 оны 04 сарын 04-ний өдөр батлагдсан байсан „Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль“-д 1996 оны 01 сарын 16-нд нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Цаг үеийн нөхцөлтэй уялдсан өөрчлөлтүүдийн зэрэгцээ (хууль зөрчсөн бол оногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн) энэ хууль анх удаагаа улс төрийн намуудын төрөөс санхүүжих заалтыг оруулсан юм: „Улсын Их Хуралд суудал бүхий намуудад авсан суудлын тоог баримтлан улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүжилтийн хэмжээ, олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.“ (1-р бүлэг, 5-р зүйлийн 10)¹ Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн суртчилгааг мөн шинээр тогтоов: „... Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн өмнөх сурталчилгааны зориулалттай уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг аймагт сумын Засаг дарга, нийслэлд дүүргийн Засаг даргаас зөвшөөрсөн гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулна“. (5-р бүлэг, 21-р зүйлийн 1)² Уг хуулиар сонгуулийн дүнг гаргах ажиллагааг улам тодруулж өгсөн юм. Энэ зохицуулалтаар тойргийн сонгогчдын 25 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцох юм. Хэрэв сонгуулийн дүнгээр ялагч илэрхий тодроогүй байвал дараах заалтыг мөрдөнө: “Хэрэв нэр дэвшигчийн хэн нь ч сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг саналын хуудсанд үлдээж, дахин санал авна.” (7-р бүлэг, 38-р зүйлийн 3). Дахин санал хураалтаар ялагч тодорч чадаагүй бол уг тойрсгт дахин сонгууль явагдана. Улсын Их Хурлын гишүүн нас барах, хүсэлтээрээ мандатаа өгөх болон мандатаа хураалгах тохиолдолд нөхөн сонгууль явуулах нэмэлтийг мөн хуулинд оруулсан юм (8-р бүлэг, 42-р зүйлийн 1, 2). Ийм зохицуулалттай мажоритар тогтолцоо руу шилжсэн явдал нь МАХН-ын сонгуульд ялах боломжийг нь эвслийн намуудын боловсон хүчний урьдын адил хүрэлцээгүй байдлыг мөн тооцвол нэмэгдүүлэх хандлагатай болгов. МАХН-ын удирдлага 76 сонгуулийн тойргийн хороонд идэвхитэй ажиллаж буй өөрсдийн гишүүд зэрэг итгэлтэй механизмууддаа мөн найдаж байв. Үнэхээр сонгууль явуулах ажилтнуудын 53,3 % нь МАХН-д, дөнгөж 13,7 % нь МҮАН-д, тэрчлэн 8,3 % нь МСДН-д харъяалагдаж байв.³ МАХН-ын удирдлага өөрийн байдалдаа итгэлтэй байсан учраас сонгуулийн кампанид “Ардчилсан Холбоо” эвсэлтэй харьцуулахад бага санхүүжилт зарцуулав (МАХН: 68.397.900 төгрөг, „Ардчилсан Холбоо” эвсэл: 89.439.481).⁴ МАХН нэр дэвшигчдээ сонгуулийн өдрөөс зургаан долоо хоногийн өмнө тодруулсан юм. Улсын Их Хуралд дахь МАХН-ын бүлгийн ихэнх гишүүд сонгуульд дахин нэрээ дэвшүүлэхийг зорьсон боловч МАХН дахь арай ардчилсан жигүүрүүдээс өөрсдийн хүмүүсээ нэр дэвшүүлэх шахалт мөн гарч ирэв. Эцэст нь тэд санал нэгдэж, Улсын Их Хурлын 37 гишүүнийг дахин нэр дэвшүүлж, 39 хүнийг шинээр нэр дэвшүүлэх болжээ. Сонгуулийн өрсөлдөөн аядуу явагдав. МАХН өөрийн засгийн газрын үйл ажиллагааны үр дүнг сурталчилсан бол „Ардчилсан Холбоо” эвсэл „эрх баригч засгийн газрын бодлогыг ажил хэрэгчээр шүүмжлэн альтернатив хувилбар дэвшүүлж, өөрийн мөрийн хөтөлбөр, боловсон хүчний илүүтэй чадамжийг харуулах” сурталчилгааг хийв. „Ардчилсан Холбоо” эвсэл „өмнөх сонгуулиудын кампанид ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан МАХН-ын эсрэг, анитикоммунист

¹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Хууль, Улаанбаатар 1996, 4-р тал.

² Мөн тэнд, 13-р тал.

³ Засгийн Газрын Мэдээ, 1996 оны 6-р сарын 7.

⁴ Ардын Эрх, 1996 оны 10-р сарын 10.

суртал ухуулга" хийхээс татгалзсан байна.¹ Сонгуулийн өрсөлдөөн ийнхүү асуудал хөндсөн ажил хэрэгч аргументыг урьтал болгосон чанарын шинэ нөхцөлд явагдав.

1996 оны 06-р сарын 30-нд явагдсан парламентийн сонгуульд улс төрийн 5 нам, намын 2 эвсэл, болон бие даан нэр дэвшигчид оролцов. 1992 оны сонгуульд улс төрийн 8 нам, намын 2 эвсэл, бие даагчид оролцож байсантай харьцуулахад монголын улс төрийн намуудын дүр зураг эрүүлжин тогтворжсоныг илтгэж байлаа.

Сонгох эрх бүхий нийт 1.217.227 иргэдээс 1.147.260 нь сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдэж, сонгуулийн өдөр 1.057.182 иргэн саналаа өгөв (=92,15 %).² Үүнээс 160.045 сонгуулийн эрхтэй иргэд (=13,14 %) сонгуульд оролцоогүй байна.

Сонгуулийн дүн маш гайхшрам гарсан. Сонгуулийн өмнөх санал асуулгууд хандлага өөр чигт эргэснийг илэрхийлж байсан боловч талуудын хэн нь ч сөрөг хүчин илт давуугаар ялахыг нухацтайгаар тооцоолж байсангүй. Сонгуулиар "Ардчилсан Холбоо" эвсэл УИХ-д 50 суудал, МАХН 25, МУНН 1 суудал тус тус авлаа. Ийнхүү сөрөг хүчин итгэл дүүрэн сонгуулийн ялалтыг авч чадав.

Сонгуулийн оролцоо, улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн үзүүлсэн сонгуулийн дүн

Нам, эвсэл, бие даагчид	Нэр дэвшигчдийн тоо	авсан саналын тоо	Хувь	УИХ-д авсан суудал
МАХН	76	408.979	40.48%	25
МҮАН-МСДН-ын "Ардчилсан Холбоо" эвсэл	74	469.586	46.48%	50
"Ардчилсан төр" эвсэл /МАН, МАСМН/	42	37.098	3.67%	-
Монголын Уламжлалын Нэгдсэн Нам	17	12.972	1.28%	1
Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам	32	22.350	2.21%	-
Монголын Хөрөнгөтний Нам	24	17.581	1.74%	-
Монголын Ажилчны Нам	2	1.211	0.12%	-
Бие даагчид	35	31.072	3.07%	-

Эх сурвалж: Ч. Дашзвэг, МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996), Улаанбаатар 1998, 248-р тал, "Өдрийн сонин" 2000 оны 05 сарын 24.

Гэвч "Ардчилсан Холбоо" эвсэл парламентийн гуравны хоёроор олонхи болоход тун ойрхон дутсан юм. Дээрх хүснэгтээс үзэхэд, сөрөг хүчний намууд өргөн хэмжээнд эвсэл байгуулсан бол илт давуугаар ялах боломж гарах байлаа. Сөрөг нам болсон МАХН-ын хувьд парламентын үйл ажиллагааны хүрээнд УИХ-ын шийдвэр, тогтоолыг бойкотлон хориг тавих боломжтой цөөнх болсон юм.

"Ардчилсан Холбоо" эвсэл сонгуулиар хотуудад төдийгүй хөдөө орон нутгуудад саналын тоогоо ахиулж чадсан бол МАХН хүн амын дээрх хоёр бүлгүүдэд хоёуланд нь саналын тооноос алдсан байх юм. Саналын хэмжээг харьцуулан үзвэл Эвсэл хотуудад, МАХН хөдөөд саналын илүү дүн үзүүлсэн байна. Намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр Монголын сонгогчдын улс

¹ W. M. Prohl, Die Parlamentswahlen in der Mongolei am 20. Juni 1996, in KAS-Auslandsinformationen 8(1996), 83-р тал.

² Х. Дашзвэг, Монгол Үндэсний Ардчилсан Намын гүүхэн тэмдэглэл (1989-1996), Улаанбаатар 1998.

төрийн сонголтоо хийхэд нь голлох үүрэгтэй болсныг дараахь хүснэгтээс харж болно:

„Сонгогчид саналаа өгөхдөө юуг нь илүү чухалчилсан бэ?”

„Нийгмийн дэвшил - Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн”-ий „Сонгогчдын боловсрол” төслийн хүрээнд явуулсан санал асуулгын дүн (%-оор)

	1990	1992	1993	1996
Мөрийн хөтөлбөр	34,4	35,5	35,3	41,9
Намын харъяалал	34,0	38,8	31,1	32,8
Хувь хүний хувьд	24,0	20,2	27,8	21,3
Мэдэхгүй	7,6	5,5	5,4	4,0

Эх сурвалж: Ч. Дашзэвэг, МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996), Улаанбаатар 1998, 245-р тал.

“Ардчилсан Холбоо” эвслийн засгийн газар Ерөнхий сайд М. Энхсайханы удирдлага дор эхний саруудад шаардлагатай хэдий ч түгээмэл бус арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Засгийн газар үнийг чөлөөлсөнөөр цахилгаан, дулааны үнэ асар хурдтай өсөн, айл өрхүүдийн амьжиргаанд хүнд цохилт болов. Засгийн газар хувьчлалын үйл явцыг түргэтгэн, татварын тогтолцоог өөрчилж, импортын татварыг багасгах зэрэг арга хэмжээг дараалан авав. Өдөр тутмын хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ болон үйлчилгээний тариф эрх барих хугацааны хоёрдугаар хагаст 40 орчим хувиар өслөө. Цалингийн хэмжээ нэмэгдэлгүй тогтмол түвшинд байснаар хүн амын бодит орлого 32 орчим хувиар багассан юм. Эвслийн засгийн газрын хэзээ ч дахин засаж боломгүй гаргасан том алдааны нэг нь өмнөх коммунист намуудын хэрэглэдэг байсан загвараар засаг захиргааны байгууллагуудад “цэвэрлэгээ” явуулж, МАХН-ын олон гишүүдийг ажлаас нь халсан явдал байв. “Ардчилсан Холбоо” эвсэл удирдах албан тушаалд ажиллаж байсан хүмүүсийг сэлгэхдээ тэдэнтэй эн зэрэгцэх, сайн бэлтгэгдсэн боловсон хүчний нөөцөөр хангалтгүй байгаагаа анхаарсангүй. Түүнчлэн эвсэл МАХН-ын зөв сэтгэлгээтэй маш олон хүмүүсийг цааш нь түлхэснээр МАХН-ын удирдлага богино хугацаанд дотоод эв нэгдлээ чангатгахын сацуу намын дотоод асуудлаа шийдвэрлэх үйл явцыг хурдасгахад нь санаатай бусаар нэмэр болж өгсөн юм. Эцэстээ энэ нь 2000 оны сонгуулийн ялагдлын дараагаар энэ үйлдэлдээ өөрсдөө гашуунаар өртөх болсон механизмын үйлчлэл байлаа.

“Ардчилсан Холбоо” эвслийн засгийн газрын нэр хүнд богино хугацаанд унасан бол МАХН-ын удирдлага улс төрийн хүчтэй нөлөөллөө дахин сэргээж тогтворжуулах арга хэмжээг эрчимтэйгээр авч хэрэгжүүлсэн юм.¹ Тус нам удахгүй болох орон нутгийн сонгуульд хангалттай дүн үзүүлснээр улс төрийн хүчний харьцааг тэнцвэржүүлэх зорилт руу үйл ажиллагаагаа чиглүүлэв. Намын удирдлага орон нутгийн намын бүтцээрээ дамжуулан тэдгээрт нөлөөгөө өргөтгөх ажлаа эрчимжүүлэв.² “Ардчилсан Холбоо” эвслийн намууд МАХН-ынхтай дүйцэхүйц орон нутгийн бүтэцгүй байсан учраас МАХН-ын хувьд үүнийгээ амжилттай хэрэгжүүлэх боломж их байв. Өрхийн амьдрал дахь эдийн засгийн илт хүнд бэрхшээлийг улс төрийн том капитал болгон ашиглаж болох овжин менежментийг МАХН олж чадсан байлаа. Энэ тооцоолол биелэлээ олов. 1996 оны 10-р сарын 06-нд явагдсан орон нутгийн сонгуулиар, өөрөөр хэлбэл “Ардчилсан Холбоо” эвсэл засгийн эрхэнд гарснаас хойш гуравхан сарын дараагаар, МАХН 12 аймаг, нийслэл Улаанбаатарт ялалт байгуулсан бол

¹ U. E. Barkmann, Die Mongolische Revolutionäre Volkspartei (MRVP) im Spagat zwischen Demokratie und Geopolitik, *Asien, Afrika, Lateinamerika*, vol. 28(2000), 265-309-р тал.

² Орон нутгийн сонгуулийн дүн, түүнээс хийх улс төрийн дүгнэлт, сургамж, *Үнэн*, 1996 оны 12-р сарын 11.

“Ардчилсан Холбоо” эвсэл ердөө л 6 аймагт ялжээ.¹ Энэ сонгуулийн дараагаар зарим аймгуудад МАХН-аас Засаг даргад нэр дэвшүүлсэн хүмүүсийг батлахад саад учруулах маневрыг “Ардчилсан Холбоо” эвсэл хэрэглэсэн нь тэдгээр аймгуудын сонгогчдод үл таашаам гүн сэтгэгдлийг үлдээсэн юм.

МАХН-ын дотоодод намын үзэл баримтлалыг тодорхойлох ширүүн маргаан өрнөж байв. Нөлөө бүхий намын зүтгэлтнүүд социалист чиг баримжаатай нам болох ёстой хэмээн үзэж байсан юм. Тэд „орчин үеийн социалист нам“ гэсэн имиштэйгээр МАХН 30-45 насны бүлгийг өөртөө илүү татаж чадна гэсэн итгэл үнэмшилтэй байсан юм. Энэ насны ангилал – 1998 оны хүн амын тоог үндэслэвэл – сонгуулийн хүн амын 37,5 %-ийг ямартаа ч эзэлж байгаа юм. Энэ насны бүлгийн сонгуулийн стратегийн ач холбогдол нь маш их юм, учир нь ирээдүйн сонгогчид болох арван найм хүртэлх насныхан нийт хүн амын 47,46 %-ийг эзэлж буйд оршино. МАХН-ын XXII Их Хурал (1997 оны 02-р сарын 21.-24.) шинэ Сонгуулийн мөрийн хөтөлбөр баталж, үүндээ МАХН үндэсний онцлогийг багтаасан зүүн төвийн нам болохыг тунхагласан юм. МАХН ардчилсан социализмын үзэл баримтлалыг авав. Шинээр сонгогдсон намын дарга Н. Энхбаяр энэ талаар намын хурал дээр: „Ардчилсан социалист үзэл санааны үндсэн агуулга нь эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийн зарчмуудаар тодорхойлогддог.“² МАХН ийнхүү дахин зүүний нам боллоо. Сүүлийн жилүүдэд өөрийнх нь намын адилшаал алдагдаж буйд санаа зовниж байсан нөхдүүдийн сэтгэл сая амрав.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгууль

МАХН-ын удирдлага ерөнхийлөгчийн сонгуульд эрчимтэй оролцохоор бэлтгэж эхэллээ. Хэрэв МАХН зөв хүнээ нэр дэвшүүлж чадвал сонгогчид итгэл хүлээлгэж болох юм гэсэн таамаглал олон нийтийн дунд оршиж байв. МАХН-д ойр ажилладаг судалгааны „Прогноз“ төвийн 1997 оны 04 сард явуулсан санал асуулгын дүн олон нийтийн дундах санаа бодол өөрчлөгдсөнийг харуулав. Санал асуулгад оролцогчдын 40 % нь амьдрал өнгөрсөн жилтэй харьцуулахад муудсан гэж хариулжээ. 84,5 % нь цалингийн орлогоороо хоол хүнс, байрны хөлсөө төлөх боломжгүй гэсэн байна. 72,7 % нь нийгэм-эдийн засгийн байдлыг „муу/маш муу“ гэж дүгнэсэн бол 55,3 % нь энэ байдлыг “Ардчилсан Холбоо” эвсэл засгийн эрх авсантай холбоотой гэж үзсэн байна. Сонгогчдын зарим нь улс орон дахь тогтворгүй байдлын улмаас хүчтэй Ерөнхийлөгчийг хүсэмжилсэн байна. “Ардчилсан Холбоо” эвслээс сонгуульд дахин нэр дэвшсэн Ерөнхийлөгч П.Очирбат хүчтэй Ерөнхийлөгч гэхээсээ илүүтэй тэнцвэржүүлэгч улс төрч гэдгээр тооцогддог байв. МАХН-ын удирдлага 2-р Бага хурлаараа Н. Багабанди, П. Жасрай, Ж. Гомбожав, Л. Түдэв нарыг нэр дэвшигчдийн жагсаалтад оруулсан ба Н.Багабанди Бага хурлын төлөөлөгчдийн 71,93 %-ийн саналаар Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшлээ. Н. Багабанди МАХН-ын шинэчлэгчдийн бүлэгт багтаж байсан ба өөрийн хатуу байр суурьтай улс төрч гэж үнэлэгддэг нэгэн юм. Сонгуулийн өмнөх олон нийтийн санал асуулгаар тэрээр бусад нэр дэвшигчдээс тасархай түрүүлж байв.

Сонгуулийн өмнөх санал асуулгын дүн

	Н. Багабанди	П. Очирбат	Ж. Гомбожав	Мэдэхгүй
1997.04.13.	46,0	24,7	8,9	20,4
1997.04.20.	53,0	25,8	7,3	13,9
1997.04.27.	50,3	30,0	6,1	13,6

¹ МАХН тус орон нутгийн сонгуульд Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Говьсүмбэр аймаг болон Улаанбаатар нийслэлд ялалт байгуулав. Ардчилсан Холбоо Архангай, Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл, Хэнтий болон Орхон аймагт ялалт байгуулав.

² Н. Энхбаяр, МАХН-ын шинэчлэлийн тулгамдсан зорилтууд, МАХН-ын XXII Их Хурал, Улаанбаатар 1997 оны 2-р сарын 21-24 хүртэл, 31-р тал.

1997.05.04.	47,0	36,1	5,6	6,5
-------------	------	------	-----	-----

Эх сурвалж: Маш нууц 7 (1997 оны 5-р сар)

1997 оны 05 сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар Н. Багабанди нийт саналын 60,8 %-иар ялна гэж хэн ч харин төсөөлсөнгүй. Сонгуулийн дүн МАХН-ын хувьд маш том ялалт болсон юм. Энэ удаагийн сонгуульд сонгуулийн насны 1.155.228 иргэд бүртгэгдсэнээс 982.640 нь санааа өгч, сонгуулийн оролцоо 85,1 %-тай байв.¹ Үүний дараа УИХ-ын 21, 37-р тойргуудад болсон нөхөн сонгуульд мөн МАХН түрүүлэв. МАХН-ын даргаар Н. Энхбаяр, МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар Л. Энэбиш гэсэн харисматик хүмүүс сонгогдсоноор МАХН-ын шинэчлэлийн бүлэг намыг удирдах болсон юм.

МАХН-ын удирдлага намаа тууштай шинэчилсэн төдийгүй улс төрийн амжилтанд мөн хүргэж чадлаа. Тэгвэл "Ардчилсан Холбоо" эвсэл улс төрийн санаачлагаа алдсан юм. "Ардчилсан Холбоо" эвслийн гол хөдөлгүүр болж байсан МҮАН гүн хямралд автав. 1996 оны сонгуулийн ялалт нь уг нам үнэн хэрэгтээ ерөөсөө тогтворжин төлөвшсөн нам болж чадаагүйг нууцалж өгсөн явдал болсон байлаа. Энэ нам өмнөхийн адил суурь бүтэцгүй байсан ба улс орноо хөгжүүлэх хөгжлийн ямар ч стратегигүй байлаа. Ерөнхий сайд М. Энхсайханы кабинет 1998 оны 04-р сарын 22-нд огцорсны дараачаар намын боловсон хүчний хүрэлцээ улам дутагдав. Түүний дараагийн засгийн газрууд болох Ц. Элбэгдорж, Ж. Наранцацралт, Р. Амаржаргал нарын засгийн газар зөвхөн зохих болзолд л ажиллах чадамжтай байлаа. Үүнд тодорхой шалтгаан бий. Дээрх засгийн газрууд УИХ дахь намын бүлэг болон намаасаа хангалттай дэмжлэг авч чадаж байгаагүй юм. Улс төрийн тодорхой үзэл баримтлал, үзэл санаагүй байсан МҮАН болоод МСДН-д намын гишүүдээ нэгтгэн, тэднийгээ идэвхижүүлэх, хөдөлгөх хүч чадавхи байсангүй. "Ардчилсан Холбоо" эвслийн дотоод улс төрийн хямралын улмаас 1998-2000 онуудад үзэл баримтлалынхаа их бага хэмжээгээр МҮАН-ын улс төрийн салаалалд багтаж болох олон шинэ намууд байгуулагдаж, Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй намуудын тоо эрс өссөн юм. 1995-1997 онуудад арван нэгэн нам бүртгэлтэй байсан бол 1998 онд арван тав, 1999 онд арван долоо болж, 2000 онд зарим намууд нэгдсэн хэдий ч арван найман нам болсон байлаа. 2000 онд МҮАН-ын хэсэг гишүүд намаа орхин Иргэний Зориг Намыг, МСДН-ын зарим гишүүд Монголын Шинэ Социал-Демократ Намыг таслан байгуулсан ба энэ нь сүүлдээ улс төрийн хувьд зөвхөн сөрөг үр дагавар авч ирэх нь батлагдсан юм. Ардчилсан хүчний намууд хуваагдан бутрав. Шинээр үүссэн намуудаас аль нь ч дараа нь улс төрийн нөлөө бүхий нам болох хэмжээнд хүрсэнгүй. Эдгээр намуудад суурь нэгжүүд байгаагүй ба улс төрийн амьдралд өөрийн орон зайтай болж чадсангүй. Үнэн хэрэг дээрээ эдгээр намууд өөрийн гэсэн өнгө, үзэл баримтлалгүй байсанд хамгийн гол хүндрэл нь оршиж байв. Эдгээр намуудын адилшаал, ялгарал нь их бага хэмжээгээр намаа улс төрийн бизнесийн унаа болгон ашиглаж байсан нэг хэсэг бие хүмүүсээр л илэрч байсан юм.

1998 оны 10-р сарын 02-нд Ардчилсан Хөдөлгөөний удирдагч С. Зориг алагдав.

Эцэстээ "Ардчилсан Холбоо" эвсэл ялагдалд хүрч, Олон улсын Валютын сангийн (ОУВС) дэмжлэг ч зогсоход хүрэв. 1999 онд төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 12 %-д хүрч, инфляци хоёр оронтой тоонд очив. Гэсэн ч Р. Амаржаргал Ерөнхий сайдын засгийн газар цалинг нэмэгдүүлэв. Төсвийн сахилгыг алдсанаар ОУВС Монголд үзүүлэх тусламжаа түр зогсооход хүрсэн үр дагавар үүссэн юм.

¹ Ардчилсан төрийн сонгуулийн товчоон, Улаанбаатар 2002.

2000 оны УИХ-ын ба 2001 оны Ерөнхийлөгчийн сонгууль

“Ардчилсан Холбоо” эвслийн нэр хүнд 1999/2000 онд хамгийн доод цэгтээ очлоо. Бие даасан судалгааны байгууллагуудын санал асуулгын дүнгүүдийг үзэхэд МАХН-ын тэргүүлэх улс төрчид “өөрсдийн нэр нөлөө, ёс зүйн хэм хэмжээ, чадвараараа ард түмний хүсэл сонирхлыг төлөөлж чадна” гэдэг үндэслээр рейтинг-д дээгүүр орсон байв. Зөвхөн алагдсан улс төрч С. Зоригийн дүү, ИЗН-ыг үүсгэн байгуулагч С. Оюун л ойролцоо үнэлгээтэйгээр багтсан байлаа.¹ “Ардчилсан Холбоо” эвслийн улс төрчдөөс нэг ч хүн орсонгүй. Социологийн судалгааны “Зөгий” төв 2000 оны 06 сарын 3-5-нд 2000 орчим иргэнээс аль намд саналаа өгөхийг нь асуужээ. Үүгээр дараах дүн гарчээ:

Та яг одоо аль намд саналаа өгөх вэ? (%)

МАХН	МУАН/МАШСН	МСДН	МШСДН	МБНН	ИЗН/МНН	Бие даагч
38.6	19.6	5.6	9.7	3.9	2.5	18.4

Эх сурвалж: „Өдрийн сонин“ 06.06.2000.

Олонд хүлээн зөвшөөрөгдсөн Сант-Марал Сангийн судалгаагаар МАХН бүр 50-иас илүү хувиар ялах дүн гарчээ. Сонгуулийн өмнө “Ардчилсан Холбоо” эвслийн намууд ихээхэн идэвхигүй байсан нь гайхшрал төрүүлж байв. Б. Дэлгэрмаа, Ч. Хулан, С. Болдхэт нарын нэртэй улс төрчид нэр дэвших боломжгүй гэдгээ мэдэгдэж байлаа. Парламентийн сонгуулийн тогтолцоо нь илүүтэй бие хүнийг харж сонгодог байхад (бие даагчид өгөх санал нилээн өндөр буйг дээрх хүснэгтээс анзаарна уу.)² нэр нөлөө бүхий хүмүүс ийн харьцсан нь байдлыг улам ойлгомжгүй болгосон юм. “Ардчилсан Холбоо” эвслийн сонгуулийн бэлтгэл ажил нь ерөнхийдөө тэд улс төрийн эрх мэдлийн төлөө өрсөлдөх гэхээсээ илүү түүнээс зориудаар ухарч байна уу гэмээр сэтгэгдэл төрүүлж байсан юм.

Нэр дэвшигчдийг тодруулах ажиглагаа тэдний ямар их зөрчилтэй байгааг харуулж байв. МАХН сонгуульд амжилт үзүүлэх хамгийн боломжтой гэсэн 76 улс төрийн зүтгэлтнийг нэр дэвшүүлсэн бол тэдний нөгөө талд 12 нам, намын 3 эвслийн 560 хүн нэр дэвшиж, мөн түүнчлэн 29 хүн бие дааж оролцсон юм.³ Сонгуульд нэр дэвшигчдийн тоо ийнхүү өндөр байсан нь зарим тойрогт 13 хүртэл хүн хоорондоо өрсөлдөхөд хүргэлээ. Ардчилсан хүчнүүдэд өгөх сонгогчдын санал ингэж хуваагдах болсон нь сонгуулийн өмнө нэгэнт тодорхой болоод байв.

МАХН сонгуулийн кампанит ажлаа маш няхуур явуулав. Тус намын хошуучлагч улс төрчид нь “Ардчилсан Холбоо” эвслийн засгийн газрын алдаа, дутагдлыг сонгуулийн сэдэв болгон танилцууллаа. “Ардчилсан Холбоо” эвслийн 10 том алдаа” гэсэн гарчигтай ярилцлагад Ч. Улаан юуны өмнө эдийн засгийн зогсонги байдал, нийгмийн эмх цэгц алдагдсан тухай болон ядуурал өсөн нэмэгдэж байгааг голлон дурьдлаа.⁴ МАХН-ын төв хэвлэл “Үнэн” сонин 2000 оны 06 сарын 28-ны дугаартаа янз бүрийн намуудын нэр дэвшигчдээс хэн нь социализмын үед МАХН-ын гишүүн байсан, тэд ямар алба хашиж байсныг нийтэлсэн юм.⁵ Буддын шашинтай ойр дотно байдаг МАХН-ын дарга Н. Энхбаяр буддын хүрээнийхнийг хүртэл сонгуулийн өрсөлдөөндөө татан оролцуулав. “Жанрайсиг” хийдийн лам Б. Равсал МАХН-ын төв хэвлэл “Үнэн” сониноор дамжуулан МАХН-ын нэр дэвшигчдийн төлөө саналаа өгөхийг сонгогчдод уриалж байв.⁶ МАХН маш ойлгомжтой хэллэг бүхий сонгуулийн мөрийн

¹ Зууны Мэдээ, 2000 оны 5-р сарын 31.

² Зууны Мэдээ, 2000 оны 6-р сарын 15.

³ Өдрийн Сонин, 2000 оны 5-р сарын 24; Өдрийн Сонин, 2000 оны 6-р сарын 9.

⁴ Ч. Улаан, Ардчилсан Холбоо эвслийн 10 том алдаа, *Үнэн*, 2000 оны 4-р сарын 29.

⁵ Х. Батхаан, Нам дамжиж нэр дэвшигчид хэн бэ?, *Үнэн*, 2000 оны 6-р сарын 28.

⁶ *Үнэн*, 2000 оны 6-р сарын 29.

хөтөлбөртэйгээр сонгуулийн өрсөлдөөнд оролцсон ба тэд ялангуяа сонгогчдын залуу насны бүлэгт илүүтэй анхаарсан байв.

Улсын Их Хурлын сонгууль 2000 оны 07 сарын 2-нд явагдлаа. Сонгогчдын нэрсийн жагсаалтанд 1.247.034 сонгогч бүртгэгдэж, 1.027.990 сонгогч саналаа өгчээ. Сонгуулийн оролцоо 82,43 % байсан ба 1996 оны парламентын сонгуультай (92,14 %) харьцуулбал 9,71 %-иар доогуур байна. МАХН саналын 51,6 %-ийг авч итгэл дүүрэн ялалт байгуулсан төдийгүй УИХ-ын 76 суудлын 72-ыг авсан юм. Судалгааны дүн нь сайн нийцдэг Сант Марал Сангийн урьдчилсан таамаглал зөв болох нь ийнхүү дахин нотлогдов. Зөвхөн МАХН парламентад дангаараа бүлэг байгуулж, сөрөг намууд улс төрийн ямар ч нөлөөгүй хүчин болох байдал үүссэн юм. 2000 оны 08 сарын 09-нд батлагдсан Н. Энхбаярын засгийн газрын дэд сайд нар нь ихээхэн амжилттай бизнесменүүд байсан нь МАХН бүр сонгуулийн өмнө бизнесменүүдийн ашиг сонирхлыг улс төрийн тооцоондоо аль хэдийн оруулж сурсан байсныг илэрхийлсэн явдал байлаа.

Сонгуулийн оролцоо, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн үзүүлсэн дүн

Нам, эвсэл, бие даагчид	Нэр дэвшигчдийн тоо	Авсан саналын тоо	Хувь (%)	УИХ-д авсан суудал
МАХН	76	517.746	51,6	72
„Ардчилсан Холбоо“ эвсэл	76	133.890	13,4	1
ИЗН/Ногоон нам	76	36.196	3,6	1
Монголын Ардчилсан Шинэ Социалист нам	10	110.608	11,0	1
Бие даагчид	29	29.352	2,9	1

Эх сурвалж: P.Gluchowski, Zurück- aber nicht rückwärtsgewandt. Die Mongolische Revolutionäre Volkspartei erneut an der Macht, KAS-Auslandsinformationen 10(2000), 33-p mal.

МАХН-ын удирдлага парламент болон засгийн газрын хүрээнд бодлогоо хэрэгжүүлж эхэлснээрээ тайвширсангүй, сонгуулийн дараа жил нь буюу 2001 онд болох ерөнхийлөгчийн сонгуульд мөн хичээнгүйлэн бэлтгэсэн юм. МАХН Ерөнхийлөгч Н. Багабандийг дахин нэр дэвшүүлэх нь анхнаасаа илэрхий байлаа. Н. Багабанди ерөнхийлөгчийн албан тушаалыг улс төрийн эрх мэдлийн томоохон төв болгон өргөжүүлэхээ сайн ойлгож байсан юм. Тэрээр гадаад бодлогын гол чиглэлүүдийг тодорхойлоход жинтэй үүрэг гүйцэтгэж, БНХАУ, АНУ, ОХУ, болон Япон улстай харилцах харилцааны хөгжилд ихээхэн түлхэц өгч байв.

Н. Багабанди дахин сонгогдох нь тодорхой болоод байлаа. “Ардчилсан Холбоо” эвслээс нэр дэвшигч Р. Гончигдорж (МСДН) болон олны сайн танил бус Л. Дашням нар Н. Багабандитай өрсөлдөж ялах боломж байсангүй. 2001 оны 05 сарын 20-ны сонгуульд Н. Багабанди хүчинтэй саналын 58,1 %-иар ялсан нь гайхах хэрэг биш байлаа. Сонгуулийн нэрсийн жагсаалтанд 1.205.885 сонгогч бүртгэгдсэнээс 1.000.125 сонгогч саналаа өгөв. Сонгуулийн оролцоо 82,9 % байв. Өрсөлдөгч Р. Гончигдорж саналын 36,53 %-ийг авсан юм.

МАХН ийнхүү парламентын суудлын үнэмлэхүй олонхийг эзэмших болсон юм. Ингэснээр тэд улс төрийн хүссэн асуудлаараа зохих хуулиудыг батлан гаргах болсон ба бүр Үндсэн Хуулинд хүртэл өөрчлөлт оруулж чадсан юм. Засгийн газраа тэд дангаараа бүрдүүлэв. Тэдний талын хүн Ерөнхийлөгчийн албыг хашиж байна. Ийнхүү энэ намын улс төрийн хариуцлага маш их болж нэмэгдэв. МАХН одоо „төрийн социализм“-ыг сэргээн байгуулах оролдлого хийнэ гэж зарим нь үзэж байлаа. Харин МАХН-ын удирдлага адчилсан байгууламж, зах зээлийн эдийн засгийг өргөжүүлэн байгуулахын төлөө байна. Өнөөдөр дэлхий дээр түүнээс өөр хувилбар байхгүй гэдгийг тэд мэдэж байна. Өөрсдийн байр сууриа бэхжүүлэхийг зорьж буй нь тэд засгийн эрхэнд үлдэхийн

төлөө хүсэлтэй байгааг баталж өгч буй хэрэг юм. Гэвч Монголын улс төрийн намуудын өнөөгийн ассиметрик (тэнцвэрт бус) байдал ихээхэн хүндрэл учруулж байгаа юм. Улс төрийг тэнцвэржүүлэх буюу сайжруулах тал нь алга байна. Улс төрийн мэтгэлцээн тодорхой бодлогын концепцийн үндсэн дээр явагддаг гэдгийг сөрөг хүчин өнөөг хүртэл ойлгоогүй байна. Сөрөг хүчний зарим жинтэй улс төрчид гишүүнчлэлгүй элитүүдийн намыг хөгжүүлэх тухай ярьж байгаа нь МАХН-ын эсрэг талд зогсож буй ардчиллын блок доторх хямрал, хагарал үүсч буй шалтгааныг тэд ерөөс ойлгоогүй байна гэж үзэхээс өөр аргагүй.

Дүгнэлт

Монгол оронд 1990 оноос өрнөсөн улс төрийн өөрчлөлт нь тус улс алхам алхмаар ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих боломжийг олгосон юм. Богино хугацаанд олон намын тогтолцоо бүрэлдэж, улс төрийн хүчнүүд олон ургальч үзлийн харилцаанд суралцах болов. Олон намын ийм хүрээнд МАХН өнөөг хүртэл хамгийн тогтвортой болоод том улс төрийн хүчин болон оршиж байна. Энэ нам идэвхитэй бөгөөд дайчилж болох гишүүд бүхий анхан шатуудтайн зэрэгцээ гадагш үйлчлэх хүчин чадалтай, бодлогын тодорхой хөтөлбөртэй нам юм. Ийм намын нөгөө талд үүсэл хөгжлийн хувьд дараахь хоёр үед ангилагдах олон намууд оршин байна:

1-р үе шат (1990-1997): Европын намуудын загвар (социал-демократ, экологи, шашин, иргэний либерал чиглэлийн) дээр суурилсан ардчилсан шинэ намууд үүсэн байгуулагдав.

Европын намуудын загварыг авах нь тийм ч амар зүйл биш юм. Учир нь эдгээр загварууд нь тус улсын улс төрийн нөхцөл байдалд зөвхөн тодорхой хэмжээнд тохирох юм. Үүнд хэдэн шалтгаан бий.

1. Монголчууд 1921 оноос өмнө ямар нэг улс төрийн нам, эсвэл бусад зохион байгуулалтын хэлбэр байсангүй. Өөрөөр хэлбэл 1990 оны ардчилсан өөрчлөлтийн дараа дахин залгамжлах тийм улс төрийн уламжлал социализмын үеийн өмнө байгаагүй юм.
2. Өнөөгийн Монгол улсын нийгмийн бүтцийн гол бүрэлдэхүүн хэсэг нь (мэргэжлийн ажилчид, сэхээтэн, албан хаагчид, номинклатур) социализмын хөгжлийн үед бүрэлдэн бий болсон юм. Социалист Монголд хувийн өмч гэж байсангүй. Иймээс улс төрийн хүсэл эрмэлзлийг бүрдүүлэн өрсөлдөх нийгмийн тодорхой бүлгүүд бүрэлдэн төлөвшиж чадаагүй билээ. Социалист нийгмийн богино хугацаанд хэрэгжүүлсэн шашингүйжүүлэл нь бүхэлдээ нэг дан хэвтэй (хомоген) нийгэм болоход нь мөн түлхэц болж өгөв.

Хэдий ийм боловч Монголчууд европын намуудын загваруудыг дагах болсон нь тохиолдлын байсангүй. Тус улс олон арван жил зүүн европын орнуудтай дотно холбоотой байж, хүн амын суурин соёлтой хэсэг нь европын мэдлэг, үнэлэмжийг эзэмшин, илүүтэй европжсон байсанд учир шалтгаан нь оршиж буй юм.

1990-1997 онуудад сөрөг хүчний цөмийг бүрдүүлж байсан МҮАН нь хэд хэдэн намын нэгдлийн дүнд үүсэн юм. Энэ нэгдлийн гол онцлог нь үнэндээ улс төрийн хүчнүүдийн зөвхөн тоон нэгдэл байсанд оршино. МҮАН-ын улс төрийн үзэл баримтлалын ялгарал нь их бага хэмжээгээр зөвхөн өөрийн өрсөлдөгч МАХН-аас илүү байхад л чиглэсэн байв. Энэ хандлага нь 1996 оныг хүртэлх эдийн засгийн уналтын хугацаанд хүрэлцээтэй байж чадав. Энэ үед МАХН-ын засгийн газар ажиллаж байсан ба МҮАН-ын үйл ажиллагаа өөрийн бодлогын тодорхой концепцгүйгээр тэднийг шүүмжлэхээр л хязгаарлагдаж байлаа. Гэсэн хэдий ч сонгогчдод улс төрийн хувьд өөр хувилбар байгаагүй учраас тэднийг 1996 онд ялалтад хүргэсэн юм.

2-р үе шат (1998 - одоо хүртэл): МАХН тогтворжив. Тэрээр улс төрийн үзэл баримтлалаа, Английн Лейбор намыг загвар болгон, Зүүн төвийн нам гэж тодорхойлов. МАХН сая дөнгөж Социалист Интернациональд гишүүнээр элсэв.

Улс төрийн сөрөг хүчин харин хагаран бутрав. Ардчиллын блок дахь хямралын хариуд олон тооны жижиг намууд байгуулагдлаа. Эдгээрийн зарим нь зөвхөн цаасан дээр оршин тогтнож, зарим нь зөвхөн удирдлагаасаа бүрдэж байлаа. Тэдний улс төрийн нөлөө нь үндсэндээ буурах хандлага руу чиглэж байв. МҮАН, МСДН нэгдэж Ардчилсан нам (АН) болсон нь улс төрийн хүчнүүдийн мөн л тоон үзүүлэлт бүхий нэгдэл байв. МСДН бол жинхэнэ социал-демократ үзэл бүхий нам биш гэсэн байр сууриа илэрхийлэгчдийн хувьд уг нэгдэл баталгаа нь болж өглөө.

Хэрэв Ардчилсан нам өөрийн гишүүд дэмжигчдээ нэгтгэсэн, тэднийг дайчлан ажиллаж чадах хэмжээний маш тодорхой хөтөлбөртэй болж, анхан шатны бүтцүүд дээрээ тулгуурласан үйл ажиллагаа явуулж чадахгүй л юм бол үргэлж улс төрийн хөгжлийн араас нь харайлгах болно. Хүндрэл хаана байна гэвэл сөрөг хүчнийхэнд нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тооцон тусгаж явж ирсэн түүхэн нам, туршлага байгаагүйд оршиж байна. Зөвхөн гаднын санаа, төсөөлөл, бүтцийг авч хэрэглэснээр асуудал шийдэгдэхгүй, дотоод улс төрд ялангуяа өөрийн онцлог бүхий элементүүд зайлшгүй шаардагдана. Монголын амьдралын онцлог, ялгааг тооцсон, түүн дотор баттай, тулхтай оршиж чадах улс төрийн нам болж төлөвшснөөр Монголын улс төрийн намуудын тэнцвэрт бус байдал аажмаар арилах боломжтой.

1992-оос 2001 онуудад Монгол улсад тус бүр гурван удаа парламентын болоод ерөнхийлөгчийн сонгууль явагдсан юм. Сонгуулийн насны иргэдийн тоо 1.085.099-өөс (1992 он) 1.205.885 (2001) болсон нь 10,01 %-иар нэмэгдсэн тоо гарч байна. 2001 оны хүн амын тоонд харьцуулахад сонгуулийн насны иргэдийн тоо 18 хүртэлх насны иргэдийн тоотой ойролцоо гарч байгаа юм. Энэ нь юуг илэрхийлж байна гэхээр, дараагийн жилүүдэд анхлан болон залуу сонгогчид олноор түрэн орж ирснээр тэднийг 35 хүртэлх насны сонгогчидтой хамтатгавал сонгуулийг шийдэх хүртэл хэмжээний том бүлэг бүрдэх юм. Юутай ч энэ насны бүлгийн сонгогчдын тоо нийт сонгогчдын 70 орчим хувийг эзэлж байна.

Сонгуулийн насны иргэдийн тоог насаар нь ангилсан байдал

Насны ангилал	15-19 настай	20-24 настай	25-29 настай	30-34 настай	нийт	Сонгогчдын нэрсийн жагсаалтад бичигдсэн сонгогчид
2000	276.600	249.400	219.800	190.600	936.400	1.247.034
2001	284.000	256.400	225.800	193.800	960.000	1.205.885

Эх сурвалж: Насны ангиллыг тоо баримтыг: Монголын статистикийн эмхтгэл 2001, Улаанбаатар 2002, 40-р тал, Нэрсийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоог: Ардчилсан төрийн сонгуулийн товчоон, Улаанбаатар 2002.

Дээр дурьдагдсан насны ангилалууд нь хөдөө-нүүдлийн болон хот-суурин амьдралын тодорхой онцлогийг тухайлан шингээсэн байгаа хэдий ч ялангуяа 18-аас 25 хүртэлх насны бүлгүүдийг хамарсан залуучуудын хэсэг нь үндсэндээ ижил төстэй шинжийг агуулж байгаа юм. Нэгтгэвээс энэ насныхан сонгогчдын 25 орчим хувийг эзэлж байна. Эдгээр залуучууд өсөлт-хөгжлийнхөө хамгийн чухал үеийг шилжилтийн үеийн хүнд хэцүү нөхцөлд өнгөрүүлсэн учраас улс төрийг сонирхох болон түүнд оролцох нь бага байна. Тэдний тун цөөхөн хэсэг нь сонин хэвлэл уншиж, эсвэл электрон хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн үйл явцыг үзэж байна. Энэ бүлгийн залуучуудын идэвхигүй байдал нь тэднийг

намууд улс төрийн *message*-ээр өөртөө татаж үл чадах бүлэг болгоод байна. МАХН-ыг эс тооцвол өөр ямар ч улс төрийн нам чухамхүү дээрх насны, ойрын хугацаанд нийгмийн эрсдэлтэй (ажилгүй, ирээдүйн зорилгогүй) бүлэгт хамрагдаж болзошгүй залуучуудтай ажиллахгүй байгаа юм. Эдгээр залуучууд сонгуульд саналаа өгөхөөр бол гэр бүл дэх эцгийн эрхт ёсны үндсэн дээр, эцгийн нөлөөгөөр л гол төлөв оролцон өгч байна. Энэ насны залуучуудийн дийлэнхи нь эдийн засгийн шалтгаанаар, гэрлэсэн ч эцэг эхийнхээ дэргэд амьдардагт үүний уг шалтгаан нь байгаа юм.

Эдгээр залуучуудын сонгуулийн оролцоо хичнээн хувьтай байгааг нарийвчлан судалж гаргасан, үзэж харчихмаар судалгаа, дүн өнөөг хүртэл алга. 18-25 насны залуучуудын сонгуульд оролцох байдал улам багасах магадлалтай байна, учир нь тэдэнд улс төрийн ямар нэг намын төлөө гэсэн сэтгэгдэл төрөхгүй байгаад оршиж байна.

Сүүлийн зургаан сонгуулийн оролцоог авч үзвэл Монголын иргэд ардчилсан тогтолцоонд харьцангуй тасралтгүй итгэл үзүүлсээр байгаа хэдий ч оролцооны хувь мэдэгдэхүйц буурч байна.

Сонгуульд санал өгсөн байдал

(УИХ=УИХ-ын сонгууль, Ерөнх.=Ерөнхийлөгчийн сонгууль, I=сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо, II=сонгуулийн оролцоо хувьд шилжүүлснээр)

	УИХ 1992	Ерөнх. 1993	УИХ 1996	Ерөнх. 1997	УИХ 2000	Ерөнх. 2001
I	1.085.099	1.106.403	1.147.268	1.155.228	1.247.034	1.205.855
II	95,6	92,7	92,14	85,1	82,43	82,9

Төр, захиргааны байгууллагын өндөр албан тушаалтнуудын дотор байгаа авилгал, коррупцийн эсрэг тэмцэх тэмцэл нь Монголчууд цаашид ардчилсан тогтолцоонд итгэл үзүүлэх эсэхтэй ихээхэн хамааралтай байх болно. Сүүлийн жилүүдэд авилгал, хээл хахуулийн хэмжээ улам өссөөр байна. Үүнтэй зэрэгцээд хүн ам доторх ядуурлын хэмжээ ч ихсэж байна, нэг үгээр өөрсдийн асуудлаа мөнгө, бусад замаар шийдэх шийдүүлэх гэж хүмүүсийн хэсэг ойрын хугацаанд багасна. Ингэснээр ниймийн зөрчлийн потенциаль ихсэж, Монголын нийгэм нэгэн шинэ сорилттой тулгарах болно.

Бүхэлд нь авч үзвэл Монголчууд ардчилсан тогтолцоог хүлээн зөвшөөрөөд байна. Энэхүү тогтолцоо цаашид оршин тогтнох эсэх нь Монголын улс төрийн намууд, улс төрчид залуу үеийнхнийг энэ ардчилсан тогтолцоонд хэрхэн интеграцчилж, асуудлыг нь шийдвэрлэн, Монголын нийгмийн хорт хавдрын голомт болсон авилгалын эсрэг хэр зэрэг амжилттай тэмцэхээс эцэслэн хамаарах болно.

Ардчилсан нийгмийн тогтвортой хөгжил нь Орос, Хятад гүрнүүдийн дунд орших Монгол төр-үндэстний цаашдын итгэл төгс оршин тогтнохын чухал баталгаа байх болно. Монголын улс төрчид энэ бодит байдлыг гүнээ ойлгож байгаа гэж л найдъя!!